

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

152.	Чөлөөт бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/	403
153.	Чөлөөт бүсийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	419
154.	“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	419
155.	“Замын-үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	420
156.	“Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	420
157.	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт оруулах тухай	421
158.	Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	421
159.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	422



160.	Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	422
161.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	423
162.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	423
163.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	424
164.	Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	425
165.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	425
166.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	426
167.	Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	426
168.	Хилийн боомтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	427
169.	Чөлөөт бүсийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	427

170.	Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	428
171.	Монгол хэлний тухай	428
172.	Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	440
173.	Өрийн удирдлагын тухай	441
174.	Өрийн удирдлагын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	486
175.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	487
176.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	489
177.	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	493
178.	Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	494
179.	Валютын зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	495
180.	Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай	495



181.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	496
182.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	497
183.	Концессын тухай хуульд нэмэлт оруулах тухай	498
184.	Хүнсний тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай	499
185.	Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	499
186.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	500
187.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай	500
188.	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	501
189.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай	503



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

190.	“Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 31	503
191.	“Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 32	504
192.	“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 33	504
193.	“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 34	505
194.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай	Дугаар 36	505
195.	Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 38	507
196.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 39	510



197.	“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 40	510
198.	Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай	Дугаар 41	511
199.	Өрийн удирдлагын тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 42	522
200.	Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай	Дугаар 43	522
201.	Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 44	523
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
202.	Н.Адъяабат, Б.Суманчулуун нарт олгосон улсын цолыг хасах тухай	Дугаар 33	524

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомж

2.1.Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“чөлөөт бүс” гэж гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг;

3.1.2.“чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэм” гэж хөрөнгө оруулалтыг татах, шинэ технологийг нэвтрүүлэх, экспортыг дэмжих, аялал жуулчлал, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэнийг гаалийн татвар болон бусад татвараас хөнгөлөх, чөлөөлөх, шалган нэвтрүүлэх, бүртгэх,

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



гаалийн хяналт тавих, чөлөөт бүсэд зорчих, хөдөлмөр эрхлэх хөнгөвчилсөн нөхцөлийн талаар энэ хуульд заасан тусгай зохицуулалтыг;

3.1.3.“гаалийн нутаг дэвсгэр” гэж Гаалийн тухай хуулийн² 4.1-д заасныг;

3.1.4.“гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт” гэж Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасныг;

3.1.5.“тарифын бус хязгаарлалт” гэж Гаалийн тухай хуулийн 3.1.14-т заасныг;

3.1.6.“худалдааг хөнгөвчлөх” гэж Хилийн боомтын тухай хуулийн³ 4.1.13-т заасныг;

3.1.7.“зураасан код” гэж Хилийн боомтын тухай хуулийн 4.1.14-т заасныг;

3.1.8.“чөлөөт бүсэд зорчих” гэж Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан болон хувийн хэргээр чөлөөт бүсэд нэвтрэхийг;

3.1.9.“монголын бараа” гэж Гаалийн тухай хуулийн 3.1.2-т заасныг;

3.1.10.“чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бараа” гэж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан нэмэгдсэн өртгийн 40-өөс дээш хувь нь чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт бий болсон барааг;

3.1.11.“хил дамнасан чөлөөт бүс” гэж хил залгаа улсын хилийн боомтын газар нутагт Засгийн газар хоорондын хэлэлцээрт үндэслэн байгуулсан чөлөөт бүсийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮС БАЙГУУЛАХ, ӨӨРЧЛӨХ, ТАТАН БУУЛГАХ

4 дүгээр зүйл.Чөлөөт бүс байгуулах зорилго

4.1.Чөлөөт бүс байгуулах зорилго нь тухайн бүсэд эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал,

²Гаалийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

³Хилийн боомтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2014 оны 05 дугаарт нийтлэгдсэн.



хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино.

5 дугаар зүйл. Чөлөөт бүс байгуулахад баримтлах зарчим, угтвар нөхцөл

5.1. Чөлөөт бүсийг байгуулахад төрөөс дараах зарчим, нөхцөлийг баримтална:

5.1.1. бизнесийг дэмжих зорилгоор нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөнд суурилсан байх;

5.1.2. чөлөөт бүс байрлах бүс нутагт авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал зэрэг шаардлагатай дэд бүтэцтэй байх буюу эдгээр дэд бүтцийг хөгжүүлэх боломжтой байх;

5.1.3. чөлөөт бүсэд ашиглах усны нөөц, эрчим хүчний хангамжтай байх;

5.1.4. хот байгуулалтын норм, дүрэм, стандарт, орон зайн нөхцөлийг хангасан байх;

5.1.5. чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгж, байгууллага итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин, нөхцөл бий болгох;

5.1.6. байгаль орчинд ээлтэй байх;

5.1.7. бүс нутгийн тогтвортой хөгжил, орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ажилтныг бэлтгэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байх.

6 дугаар зүйл. Чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох

6.1. Монгол Улсад чөлөөт бүс байгуулах, түүний байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааны чиглэл, төрлийг тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

6.2. Чөлөөт бүсийг хилийн боомтын болон Засгийн газрын санал болгосон бүс нутагт байгуулна.



6.3.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу хил дамнасан чөлөөт бүс байгуулж болох бөгөөд уг чөлөөт бүсэд баримтлах бодлого, чиглэлийг холбогдох улстай байгуулсан гэрээгээр зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН УДИРДЛАГА

7 дугаар зүйл.Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1.Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.чөлөөт бүсийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг боловсруулах;

7.1.2.чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах талаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах;

7.1.3.чөлөөт бүсийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах;

7.1.4.чөлөөт бүсийн үйл ажиллагааг жил бүр Засгийн газарт тайлагнах;

7.1.5.чөлөөт бүсийн талаарх төрийн зохицуулалт, үйл ажиллагаатай холбоотой төсвийг боловсруулах;

7.1.6.чөлөөт бүс дэх төрийн байгууллага болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

7.1.7.чөлөөт бүсэд зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийг удирдлагаар хангаж, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

7.1.8.чөлөөт бүсийн хөгжлийн төсөл болон чөлөөт бүсийн талаар Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.9.чөлөөт бүсийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах;

7.1.10.энэ хуулийн 21.1-д заасан Хөрөнгө оруулагчдын зөвлөлөөс санал болгосон төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулахад тавих шалгуур үзүүлэлтийг тогтоох.



8 дугаар зүйл. Чөлөөт бүсийн захирагч, түүний бүрэн эрх

8.1. Чөлөөт бүсийн захирагч чөлөөт бүсэд төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн.

8.2. Чөлөөт бүсийн захирагчийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

8.3. Чөлөөт бүсийн захирагч ажлаа чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцна.

8.4. Чөлөөт бүсийн захирагч ажлын албатай байх бөгөөд уг ажлын албаны бүтэц, орон тоо, зардлын хязгаарыг Засгийн газар тогтооно.

8.5. Чөлөөт бүсийн захирагч тогтоосон загварын тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

8.6. Чөлөөт бүсийн захирагч эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргах бөгөөд уг захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өөрчлөх буюу хүчингүй болгоно.

8.7. Чөлөөт бүсийн захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.7.1. чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар чөлөөт бүсийг төлөөлөх, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах;

8.7.2. чөлөөт бүсийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах;

8.7.3. чөлөөт бүсийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийх;

8.7.4. чөлөөт бүсийн ажиллах хүчний болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх;

8.7.5. чөлөөт бүсийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалтыг хариуцах, хяналт тавих;

8.7.6. чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах;



8.7.7.чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох;

8.7.8.энэ хуулийн 21.1-д заасан Хөрөнгө оруулагчдын зөвлөл болон бусад байгууллагатай хамтран ажиллах;

8.7.9.чөлөөт бүсэд гарал үүсэл нь тодорхой, барааны тэмдэг, зураасан кодтой барааг худалдах талаар аж ахуй эрхлэгчид шаардлага тавих;

8.7.10.чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт нийгмийн хэв журмыг сахиулах, галын аюулаас хамгаалах, яаралтай тусламж үзүүлэх зэрэг үйлчилгээг зохицуулж хэрэгжүүлэх;

8.7.11.чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах, эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу олгох.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ДЭГЛЭМ

9 дүгээр зүйл.Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэмийн зохицуулалт

9.1.Чөлөөт бүсэд гаалийн, визийн, Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, хуулийн этгээдийн бүртгэлийн, валют зохицуулалтын, мэргэжлийн хяналтын, хөдөлмөр эрхлэлтийн, татварын болон бусад тусгай дэглэм үйлчилнэ.

9.2.Чөлөөт бүс дэх төрийн үйлчилгээ нь худалдаа, татварын харилцаа, бизнес, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилна.

10 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх гаалийн тусгай дэглэм

10.1.Барааг чөлөөт бүсэд оруулахад дараах баримт бичгийг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийнэ:

10.1.1.хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах бараанд ачааны манифест, тээврийн баримт бичиг, шаардлагатай тохиолдолд холбогдох зөвшөөрөл, лиценз;



10.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулах бараанд энэ хуулийн 10.1.1-д заасан баримт бичгээс гадна татвар төлсөн баримт.

10.2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн⁴ 38.1.4-т зааснаас гадна зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

10.3.Хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифын бус хязгаарлалт тогтоохгүй.

10.4.Барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

10.5.Чөлөөт бүсэд нэвтрүүлж байгаа бараанд эрсдэлд суурилсан гаалийн хяналтыг тавина.

10.6.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь гаалийн байгууллагатай цахим мэдээллийн сүлжээнд холбогдсон байх бөгөөд чөлөөт бүсэд нэвтрүүлсэн барааны бүртгэлийг цахим хэлбэрээр хөтөлнө.

11 дүгээр зүйл.Чөлөөт бүс дэх визийн тусгай дэглэм

11.1.Хилийн боомтод байрлалтай чөлөөт бүсэд хил залгаа улсын иргэн 30 хоногийн хугацаагаар визгүй, гуравдагч улсын иргэн харилцан зорчих нөхцөлийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зорчино.

11.2.Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй болон “орох-гарах” визтэй гадаадын иргэн оршин суух болон визийн байх хугацаанд аль ч чөлөөт бүсэд визгүй зорчино.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний визийн байх хугацаа болон визгүй зорчих хугацааг нэг удаад 30 хүртэл хоногоор сунгаж болно.

11.4.Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн чөлөөт бүсэд дараах баримт бичгийн аль нэгийг шалгуулан нэвтэрнэ:

⁴Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.



11.4.1.Монгол Улсын иргэн гадаад паспорт, иргэний үнэмлэх, эсхүл жолооны үнэмлэх;

11.4.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүн гадаад паспорт, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

11.4.3.Монгол Улсын 16 насанд хүрээгүй иргэн төрсний гэрчилгээ, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг.

12 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн зохицуулалт

12.1.Чөлөөт бүсэд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд дараах баримт бичгийг бүрдүүлэн бүртгүүлнэ:

12.1.1.Монгол Улсын хуулийн этгээд бол өргөдөл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, бүртгэлийн хураамж төлсөн баримт;

12.1.2.гадаад улсын хуулийн этгээд бол өргөдөл, гадаад улсын хуулийн этгээдийг гэрчилсэн баримт бичгийн хуулбар, итгэмжлэл, бүртгэлийн хураамж төлсөн баримт.

12.2.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба энэ хуулийн 12.1-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор хянаж, холбогдох журамд заасан шаардлага хангасан гэж үзвэл чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох ба уг гэрчилгээ нь зөвхөн тухайн чөлөөт бүсэд хүчин төгөлдөр үйлчилнэ.

12.3.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн болон хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр хүргүүлнэ.

12.4.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд бүртгүүлсэн хуулийн этгээд нь бусад хуулийн этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болох бөгөөд чөлөөт бүсэд гэрээгээр хамтран ажиллах хуулийн этгээд энэ хуульд заасны дагуу бүртгүүлж, чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ авна.

12.5.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг дараах үндэслэлээр чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасна:



12.5.1.хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээг эхлүүлээгүй;

12.5.2.үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон;

12.5.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

13 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалт

13.1.Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар гүйцэтгэнэ.

13.2.Чөлөөт бүсэд банк, банк бус санхүүгийн байгууллага, түүний салбар нэгж байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл.Чөлөөт бүс дэх мэргэжлийн хяналтын зохицуулалт

14.1.Чөлөөт бүс дэх мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын төв байгууллага уялдуулан зохицуулна.

14.2.Дараах үндэслэлээр хяналт шалгалт хийнэ:

14.2.1.гаалийн хяналтын явцад мал, амьтан, ургамал, хорио цээртэй холбоотой зайлшгүй шалгах шаардлага гарсан;

14.2.2.чөлөөт бүс доторх бараа бүтээгдэхүүн, хүнсний эрүүл ахуй, барилга байгууламжийн чанар, байгаль орчны бохирдолтой холбоотой гомдол ирсэн.

15 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэм

15.1.Чөлөөт бүсэд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулахад Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн⁵ 4.1.4 дэх заалт хамаарахгүй.

⁵Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 17 дугаарт нийтлэгдсэн.



15.2.Чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсэн бол ажлын байрын төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөнө.

15.3.Чөлөөт бүсэд ажиллаж байгаа хуулийн этгээд өөрийн ажилтныг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогоос хасаж тооцно.

16 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх татварын тусгай дэглэм

16.1.Чөлөөт бүсэд татварын дараах хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчилнэ:

16.1.1.хилийн чанадаас чөлөөт бүсэд импортолсон бараанд импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй;

16.1.2.импортын гаалийн, онцгой болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг чөлөөт бүсэд оруулахад татвар ногдуулахгүй бөгөөд гаалийн нутаг дэвсгэрт тухайн татварыг төлсөн баримтыг үндэслэн бусад татвараас хасалт хийж буцаан олгох;

16.1.3.монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулахад нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувь хэмжээгээр ногдуулах;

16.1.4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.4-т зааснаас гадна зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;

16.1.5.энэ хуулийн 16.1.4-т зааснаас бусад барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон бусад татварыг холбогдох хуулийн дагуу ногдуулах;

16.1.6.барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад татвар ногдуулахгүй;

16.1.7.чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй.



16.2.Энэ хуулийн 10.2, 16.1.4-т заасан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалтыг Засгийн газар тухай бүр нь баталж болно.

16.3.Энэ хуулийн 10.2, 16.1.4-т заасан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараанд онцгой албан татвар ногдох бараа, эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн хамаарахгүй.

16.4.Чөлөөт бүсэд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дараах хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчилнэ:

16.4.1.чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх;

16.4.2.чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх;

16.4.3.чөлөөт бүсэд хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн татварын тайлангаар гарсан алдагдлыг бүтээн байгуулалтын ажил дуусаж, зорилтот үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа эхэлсний дараагийн таван жилд албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцох.

16.5.Чөлөөт бүсэд энэ хуулийн 16.1, 16.4-т зааснаас гадна дараах татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчилнэ:

16.5.1.чөлөөт бүсэд инноваци, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг ашигт үйл ажиллагаагаа эхэлсний дараагийн таван жилд ногдох орлогын албан татвараас чөлөөлөх;

16.5.2.чөлөөт бүсэд баригдаж бүртгэгдсэн барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас бүрэн чөлөөлөх.

16.6.Чөлөөт бүсэд бүртгэлтэй хуулийн этгээд нь чөлөөт бүсэд эрхэлсэн үйл ажиллагааны санхүү, татварын тайланг холбогдох журмын дагуу гаргаж, чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд хүргүүлнэ.



17 дугаар зүйл. Чөлөөт бүс дэх тусгай дэглэмийн болон бусад үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэх

17.1. Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба улсын бүртгэл, татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэх ажлыг тухайн төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

17.2. Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нийгмийн хэв журам сахиулах, галын аюулаас хамгаалах, эмнэлгийн яаралтай тусламж, эрүүл ахуй болон дэд бүтцийн хангалтын үйлчилгээ зэргийг тухайн асуудал хариуцсан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

17.3. Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба энэ хуулийн 17.2-т заасан үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагад хууль тогтоомжид заасны дагуу гаргаж өгнө.

ТАВДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮСЭД АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

18 дугаар зүйл. Чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагааны төрөл

18.1. Чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болно.

18.2. Чөлөөт бүсэд тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн⁶ дагуу зохицуулна.

19 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлого

19.1. Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба дараах орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ:

19.1.1. чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэний орлогын албан татвар, тэдгээрээс авах хураамж;

⁶Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



19.1.2.чөлөөт бүсийн төрийн өмчийн барилга байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр;

19.1.3.газрын төлбөр;

19.1.4.бусад аж ахуйн ажил, үйлчилгээний орлого.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан орлогын 20 хүртэл хувийг чөлөөт бүсийг хөгжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг түргэтгэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор зарцуулна.

20 дугаар зүйл.Чөлөөт бүсийн захирагчаас орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргатай харилцах

20.1.Чөлөөт бүсийн захирагч нь тухайн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх асуудлаар орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргатай хамтран ажиллана.

20.2.Орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.

20.3.Чөлөөт бүс, аймаг, орон нутгийн нийтлэг ач холбогдолтой үйлдвэрлэлийн дэд бүтцийг байгаль орчинд ээлтэй байхаар хөгжүүлэх төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл.Хөрөнгө оруулагчдын зөвлөл

21.1.Чөлөөт бүс нь хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих, сурталчлах зорилго бүхий хөрөнгө оруулагчдын төлөөлөгчдөөс бүрдсэн Хөрөнгө оруулагчдын зөвлөлтэй байна.

21.2.Хөрөнгө оруулагчдын зөвлөл нь хурлаараа баталсан дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулна.

21.3.Хөрөнгө оруулагч нь чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр чөлөөт бүсийн менежментийг хэрэгжүүлж болно.



ЗУРГААДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ГАЗРЫН ХАРИЛЦАА

22 дугаар зүйл. Газрын зохицуулалт

22.1. Чөлөөт бүсийн газар нь боомтын газар нутагт хамаарахгүй.

22.2. Чөлөөт бүс доторх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэрийг чөлөөт бүсийн захирагч гаргаж, түүний ажлын алба газар эзэмшигч, газар ашиглагчтай гэрээ байгуулах бөгөөд уг шийдвэрт эзэмших, ашиглах газрын хэмжээ, хугацааг тусгасан байна.

22.3. Чөлөөт бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах газрын суурь үнэлгээ болон газрын төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно.

22.4. Газар эзэмших, ашиглах эрхийг төсөл сонгон шалгаруулах, дуудлага худалдааны аль нэг хэлбэрийг ашиглан олгоно.

22.5. Чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төсөл сонгон шалгаруулалтаар авсан хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу итгэлцүүрээр тогтоосон дуудлага худалдааны анхны үнэтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн төлбөрөө төлсний дараа газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээ олгоно.

22.6. Энэ хуулийн 12.5.1, 12.5.2-т заасан нөхцөл байдал үүссэн аж ахуйн нэгжийн газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгоно.

22.7. Чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Газрын тухай хуулиар⁷ зохицуулна.

23 дугаар зүйл. Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт

23.1. Худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар хөнгөлнө.

23.2. Чөлөөт бүсэд эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтэц болон үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, түүний салбарыг

⁷Газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний 10 жилд 100 хувиар чөлөөлнө.

23.3.Чөлөөт бүсэд газар ашиглах, эзэмших гэрээ байгуулсан Монгол Улсын болон гадаадын хуулийн этгээд, иргэн газрын үр өгөөжийг ашиглах, эзэмших, хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдлыг нь харгалзан тэдгээрийг газрын төлбөрөөс тодорхой хугацаагаар хөнгөлж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан газрын төлбөрөөс хөнгөлөх хугацаа, хувь хэмжээг тогтоох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ДЭД БҮТЭЦ

24 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн дэд бүтэц, барилга байгууламж

24.1.Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газар батална.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасан ерөнхий төлөвлөгөөний дагуу чөлөөт бүсийн хот байгуулалт, дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгуулахтай холбогдсон харилцааг Хот байгуулалтын тухай,⁸ Барилгын тухай⁹, Авто замын тухай,¹⁰ Эрчим хүчний тухай хууль¹¹ болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

24.3.Чөлөөт бүсийн дэд бүтэц, барилга байгууламжийг концессын гэрээний үндсэн дээр байгуулж болно.

24.4.Чөлөөт бүсийн дэд бүтцийг энэ хуулийн 24.3-т зааснаас гадна улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж болон Засгийн газрын бондоор санхүүжүүлж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХАРУУЛ ХАМГААЛАЛТ

25 дугаар зүйл.Чөлөөт бүсийн хамгаалалт

25.1.Чөлөөт бүс нь улсын онцгой объектод хамаарна.

⁸Хот байгуулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

⁹Барилгын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 19 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰Авто замын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1998 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

¹¹Эрчим хүчний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 06 дугаарт нийтлэгдсэн.



25.2.Хилийн боомт дахь чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг хил хамгаалах байгууллага, бусад чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэнэ.

25.3.Чөлөөт бүсийн нийтийн аюулгүй байдал, хэв журмыг сахиулах үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

26 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1.Чөлөөт бүсийн захирагч нь чөлөөт бүсэд баримтлах тусгай дэглэмийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгоно.

26.2.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэн нь чөлөөт бүсийн захирагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө дампуурснаас бусад шалтгаанаар татан буугдсан буюу чөлөөт бүс дэх үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд хөнгөлж, чөлөөлсөн татварын хувь хэмжээний нийлбэрээр тухайн аж ахуйн нэгжийн татварын өрөнд шилжүүлэн тооцно.

26.3.Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд шүүгч доор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

26.3.1.чөлөөт бүсийн тусгай дэглэмийг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.3.2.энэ хуулийн 16.1, 16.4, 16.5-д заасныг зөрчиж хөнгөлөлт, чөлөөлөлт олгосон албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан Чөлөөт бүсийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**“АЛТАНБУЛАГ” ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ
БҮСИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

“ЗАМЫН-ҮҮД” ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2003 оны 06 дугаар сарын 20-ны өдөр баталсан “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

“ЦАГААННУУР” ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталсан “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Нийгмийн даатгалын тухай хууль” гэсний дараа “, Чөлөөт бүсийн тухай хууль,” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “Засгийн газар хоорондын гэрээнд заасан тохиолдолд уг гэрээгээр ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтнуудад” гэсний дараа “, чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтанд” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.3 дахь хэсэг нэмсүгэй:

“2.3.Монгол Улсын чөлөөт бүсэд энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно.”

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “гаалийн баталгаат бүсийн” гэсний дараа “болон чөлөөт бүсийн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “болон чөлөөт бүсэд виз” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай 22¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“22¹ дүгээр зүйл.Чөлөөт бүсийн захирагчийн бүрэн эрх

22¹.1.Чөлөөт бүсийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу чөлөөт бүсийн газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.5 дахь заалт нэмсүгэй:

“7.1.5.чөлөөт бүсэд баригдаж бүртгэгдсэн барилга байгууламж.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.1.13, 18.1.14 дэх заалт:

“18.1.13.чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлого;

18.1.14.чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлого.”



2/20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг:

“20.5.Чөлөөт бүсэд хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн татварын тайлангаар гарсан алдагдлыг бүтээн байгуулалтын ажил дуусаж, зорилтот үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа эхэлсний дараагийн таван жилд албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалт:

“12.1.8.хилийн чанадаас чөлөөт бүсэд импортолсон, чөлөөт бүсээс хилийн чанадад экспортолсон бараа.”

2/13 дугаар зүйлийн 13.1.27 дахь заалт:

“13.1.27.чөлөөт бүсэд зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараа.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хот байгуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.7 дахь заалт нэмсүгэй:

“6.1.7.чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах.”

2 дугаар зүйл.Хот байгуулалтын тухай хуулийн **5 дугаар** зүйлийн 5.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.1.4.чөлөөт бүсийн хилийн цэсийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.4 дэх хэсэг нэмсүгэй:

“16.4.Чөлөөт бүсийн захирагч нь энэ хуулийн 16.2.2, 16.2.5, 16.2.6, 16.3.4-т заасан тусгай зөвшөөрлийг олгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг даргын санал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.3.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ХИЛИЙН БООМТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хилийн боомтын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.4 дэх хэсэг нэмсүгэй:

“7.4.Чөлөөт бүсийн газар нь боомтын газар нутагт хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Хилийн боомтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.3.Хилийн боомтын бүс нутагт чөлөөт бүс байгуулж болох бөгөөд түүнтэй холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөхөөс өмнө байгуулагдсан чөлөөт бүсийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсанд тооцно.

2 дугаар зүйл.Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөж эхэлснээр өмнө нь энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан чөлөөт бүсийн газар нутагт газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.



3 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 11, 12 дахь заалт нэмсүгэй:

“11/худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар;

12/чөлөөт бүсэд эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтэц болон үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, түүний салбарыг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний 10 жилд 100 хувиар.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь монгол хэл, бичиг үсгээ эзэмших,

хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол хэлний тухай хууль тогтоомж

2.1.Монгол хэлний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал², энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол уг гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бусад хуулийн этгээдэд хамаарна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төрийн албан ёсны хэл” гэж төрийн байгууллага, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөх орчин цагийн утга зохиолын монгол хэлийг;

4.1.2.“монгол хэлний хэм хэмжээ” гэж орчин цагийн утга зохиолын монгол хэлний найруулан бичих, зөв дуудах ёс, зүй тогтол, зөв бичих дүрмийг;

4.1.3.“үндэсний бичиг” гэж уламжлалт монгол бичгийг;

4.1.4.“монгол хэл, бичиг” гэж монгол хэл, кирил болон үндэсний бичгийг.

5 дугаар зүйл.Хуулийн үндсэн зарчим

5.1.Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн.

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 36 дугаарт нийтлэгдсэн.



5.2.Монгол хэл, бичиг үсгийг эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн үүрэг мөн.

5.3.Монгол Улсын иргэн бүр монгол хэл, бичиг үсгээ сурах, монгол хэлээр мэдээлэл авах, өвлөх, өвлүүлэх, хамгаалах, хөгжүүлэх боломж, нөхцөлөөр хангагдах эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ ХЭЛИЙГ ХЭРЭГЛЭХ

6 дугаар зүйл.Монгол хэлийг хэрэглэх

6.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа, албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна:

6.1.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт;

6.1.2.төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг байгууллагаас бусад бүх шатны боловсролын байгууллагын сургалт;

6.1.3.бүх шатны шүүн таслах ажиллагааны тэмдэглэл, архивын холбогдох баримт бичиг;

6.1.4.Монгол Улсын олон улсын гэрээ;

6.1.5.Монгол Улсаас гадаад улс, дипломат төлөөлөгчийн газарт илгээх албан ёсны ноот бичиг;

6.1.6.Монгол Улсын иргэний үнэмлэх, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ, үндэсний гадаад паспорт, боловсролын баримт бичиг;

6.1.7.газар нутаг, засаг захиргааны нэгж, гудамж, зам, талбай, хуулийн этгээдийн нэр, хаяг;

6.1.8.Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх бичиг, захидал хүлээн авагч, илгээгчийн хаяг;

6.1.9.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас хэвлэн гаргах мэдээлэл, товхимол;



6.1.10. олон нийтэд зориулсан зар;

6.1.11. албан байгууллага, барилга, байгууламж, нийтийн тээврийн хэрэгсэлд байрлуулах зааварчилгаа, мэдээлэл, аюулгүй ажиллагааны санамж.

6.2. Энэ хуулийн 6.1.4-6.1.6, 6.1.9-6.1.11-т заасан үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөхөд олон улсын харилцааны хэрэгцээ, шаардлагыг харгалзан гадаад хэл давхар хэрэглэж болно.

6.3. Төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг болон гадаад хэл заах тусгай зөвшөөрөл бүхий ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд гадаад хэлийг тавдугаар ангиас эхлэн зааж болно.

6.4. Газар нутаг, гудамж, зам, талбайд гадаад нэр оноох асуудлыг нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

6.5. Бүх шатны сургалт, эрдэм шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томьёог монгол хэлнээ орчуулан хэрэглэхийг эрхэмлэнэ.

6.6. Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллага Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд гадаад хэлээр хандах бол монгол орчуулгыг хавсаргана.

6.7. Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын хуулийн этгээд, төрийн бус байгууллага Монгол Улсын төрийн байгууллага, иргэнтэй монгол хэлээр харилцаж, санхүү, татвар, хөдөлмөр, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой баримт бичиг, мэдээллийг монгол хэлээр үйлдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БИЧИГ ҮСЭГ СОНГОН ХЭРЭГЛЭХ

7 дугаар зүйл. Бичиг үсэг сонгон хэрэглэх

7.1. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээд албан хэргээ кирил бичгээр хөтлөн явуулна.

7.2. Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.



7.3.Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад үндэсний бичгийг зургаадугаар ангиас эхлэн төгстөл тусгайлсан хөтөлбөрөөр заана.

7.4.Их, дээд сургуульд элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалт болон төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний шалгалтын агуулгын дөрөвний нэгээс доошгүй хувь нь үндэсний бичгийн мэдлэгийг үнэлэхэд чиглэнэ.

7.5.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас гадаад улсын адил төвшний албан тушаалтанд илгээх албан бичиг, захидлыг үндэсний бичгээр үйлдэж гадаад хэлээрх орчуулгыг хавсаргана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ ХЭЛНИЙ ЗӨВ БИЧИХ ДҮРЭМ, ТОЛЬ БИЧИГ

8 дугаар зүйл.Монгол хэлний зөв бичих дүрэм, толь бичиг

8.1.Монгол Улсын хэмжээнд кирил болон үндэсний бичгийн зөв бичих тус тусын нэгдмэл дүрэмтэй байх бөгөөд иргэн, хуулийн этгээд уг дүрмийг дагаж мөрдөнө.

8.2.Кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрэм, түүний өөрчлөлтийг энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллага хариуцан боловсруулж, 21.1-д заасан эрх бүхий байгууллага баталснаар хүчин төгөлдөр болно.

8.3.Кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрмийг баримтлан зохиосон толь бичгийг энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллага хянаж, 21.1-д заасан эрх бүхий байгууллага хэлэлцэн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ

9 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгч

9.1.Монгол Улсын Ерөнхийлөгч монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

9.1.1.монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбоотой төрийн бодлогын талаарх саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;



9.1.2.монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, анхаарах асуудлын талаар хоёр жил тутам Улсын Их Хуралд мэдээлэл хийх;

9.1.3.монгол хэл, бичиг үсгээ хэрэглэх, эзэмших, хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр зарлиг гаргах, төрийн холбогдох байгууллагад чиглэл өгөх;

9.1.4.энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлөх;

9.1.5.монгол хэл, бичиг үсгээ хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гаргасан иргэн, хуулийн этгээдэд дөрвөн жил тутамд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгох;

9.1.6.хуульд заасан бусад үүрэг.

10 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурал

10.1.Монгол Улсын Их Хурал монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

10.1.1.монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

10.1.2.монгол хэл, бичиг үсгийг хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх улс төр, эдийн засгийн баталгааг бүрдүүлэх;

10.1.3.монгол хэл, бичиг үсгийг хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.4.хуульд заасан бусад үүрэг.

11 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар

11.1.Монгол Улсын Засгийн газар монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

11.1.1.монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах;

11.1.2.монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх;



11.1.3.гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, түүний гэр бүлд монгол хэл, бичиг үсэг, уламжлалт зан заншил, түүх соёлын мэдлэг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

11.1.4.төрийн захиргааны бүх шатны байгууллагын төрийн албан хэрэгт кирил болон үндэсний бичгийн хэлний хэм хэмжээг мөрдүүлж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

11.1.5.хуульд заасан бусад үүрэг.

12 дугаар зүйл.Төрийн албаны төв байгууллага

12.1.Төрийн албаны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

12.1.1.төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний шалгалтыг энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагаас баталсан агуулгын дагуу зохион байгуулж, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх;

12.1.2.хуульд заасан бусад үүрэг.

13 дугаар зүйл.Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

13.1.Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

13.1.1.бүх шатны боловсролын сургалтын байгууллагын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын хичээлийн агуулга, хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын саналыг тусган батлах;

13.1.2.их, дээд сургуульд элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэлний шалгалтын агуулгыг энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын саналыг тусган батлах;

13.1.3.сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, уран зохиол, сэтгүүл зүйн чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэл, бичгийн шалгалтын тусгайлсан журам боловсруулах;

13.1.4.суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах;



13.1.5.үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

13.1.6.хуульд заасан бусад үүрэг.

14 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

14.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

14.1.1.монгол хэл, бичгийн соёлын өвийг хамгаалах, үндэсний монгол бичгээрх оюуны өв сан, ардын аман зохиол болон монгол утга зохиолын судалгаа, сургалтыг өргөжүүлэх ажлыг боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

14.1.2.хуульд заасан бусад үүрэг.

15 дугаар зүйл.Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

15.1.Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үүрэг хүлээнэ:

15.1.1.цахим орчинд монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх;

15.1.2.латин үсэг хэрэглэх загварчилсан дүрэм, журмыг мөрдүүлэх ажлыг энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллага, холбогдох бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

15.1.3.энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын баталсан кирил болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах болон бусад холбогдох программын хэрэглээг нэмэгдүүлэх, цахим орчинд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

15.1.4.хуульд заасан бусад үүрэг.

16 дугаар зүйл.Ерөнхий боловсролын сургууль

16.1.Ерөнхий боловсролын сургууль дараах үүрэг хүлээнэ:

16.1.1.суралцагчдад монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын хичээлийг эрх бүхий байгууллагаас баталсан хөтөлбөр, агуулга, стандартын дагуу тасалдалгүй явуулах;



16.1.2.хуульд заасан бусад үүрэг.

16.2.Энэ хуулийн 16.1.1 дэх заалт эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гадаад хэлээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуульд нэгэн адил хамаарна.

17 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга

17.1.Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ:

17.1.1.харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.2.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвших ажлыг зохион байгуулах;

17.1.3.үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллаж байгаа иргэн, хуулийн этгээдийг урамшуулах ажлыг зохион байгуулах;

17.1.4.хуульд заасан бусад үүрэг.

18 дугаар зүйл.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага

18.1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага дараах үүрэг хүлээнэ:

18.1.1.энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчлийг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх, үр дүнг шуурхай мэдээлэх;

18.1.2.хуульд заасан бусад үүрэг.

19 дүгээр зүйл.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага

19.1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага дараах үүрэг хүлээнэ:

19.1.1.монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах;



19.1.2.сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх;

19.1.3.хуульд заасан бусад үүрэг.

20 дугаар зүйл.Монгол Улсын иргэн

20.1.Монгол Улсын иргэн дараах эрх эдэлнэ:

20.1.1.монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, монгол хэлээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гаргах;

20.1.2.хуульд заасан бусад эрх.

20.2.Монгол Улсын иргэн дараах журамт үүрэг хүлээнэ:

20.2.1.монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх;

20.2.2.хуульд заасан бусад үүрэг.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

21 дүгээр зүйл.Хэлний бодлогын үндэсний зөвлөл

21.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд монгол хэлийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн үүрэг бүхий Хэлний бодлогын үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана.

21.2.Зөвлөл есөн гишүүнтэй байна. Гишүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч монгол хэл, утга зохиолын эрдэмтэн, хэвлэл мэдээлэл, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын мэргэжлийн төлөөлөөс сонгож, зургаан жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн дарга, гишүүн хүндэтгэх шалтгаанаар ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болсон нөхцөлд Монгол Улсын Ерөнхийлөгч нөхөн томилно.

21.3.Зөвлөлийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч Зөвлөлийн гишүүдийн дотроос сонгож, гурван жилийн хугацаатай томилно. Зөвлөлийн даргыг хоёроос дээшгүй удаа улируулан томилж болно.

21.4.Зөвлөл жилд хоёр удаа тогтсон хугацаанд хуралдах бөгөөд зайлшгүй шаардлага үүссэн нөхцөлд ээлжит бус хурлыг Зөвлөлийн даргын шийдвэрээр зарлан хуралдуулна.



21.5.Зөвлөл орон тооны ажлын албатай байх ба түүний өдөр тутмын үйл ажиллагааг ажлын албаны дарга удирдан явуулна.

21.6.Зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг Зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар батална.

21.7.Зөвлөл дараах үүрэг хүлээнэ:

21.7.1.монгол хэл, бичиг үсгийг хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбоотой бодлого боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

21.7.2.үндэстний цөөнхийн хэл, монгол угсаатны аман аялгууг судлах, хамгаалах, хөгжүүлэх, гадаад оронд суугаа монгол үндэстнүүд, олон улсын хэмжээнд монгол хэл, бичиг үсгийн хэрэглээ, сургалт судалгааг өргөжүүлэх, дэмжих чиглэлээр бодлого боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

21.7.3.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагаас боловсруулсан, дүгнэлт гаргасан кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрэм, түүний өөрчлөлтийг хэлэлцэн батлах;

21.7.4.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрмийн толь, үгийн сангийн толь болон бусад холбогдох толь бичгийг хэлэлцэн батлах;

21.7.5.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагаас боловсруулсан гадаад нэр томьёоны орчуулга, монгол хэлний үгийн санд оруулах шинэ нэр томьёог хэлэлцэн батлах;

21.7.6.газар нутаг, гудамж, зам, талбайд гадаад нэр оноох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж нутгийн өөрөө удирдах байгууллагад илгээх;

21.7.7.төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний төвшин тогтоох шалгалтын агуулгыг энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагаас ирүүлсний дагуу хэлэлцэн батлах;

21.7.8.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн кирил болон үндэсний бичиг рүү харилцан хөрвүүлэх, зөв бичих дүрмийн алдаа хянах программыг хэлэлцэн батлах;



21.7.9.төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага монгол хэлний хэм хэмжээг баримталж байгаа эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

21.7.10.энэ хуулийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийж, үр дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид тайлагнах;

21.7.11.энэ хуулийн хэрэгжилт, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авч, холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

21.7.12.энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ЭРХ БҮХИЙ СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГА

22 дугаар зүйл. Эрх бүхий судалгааны байгууллага

22.1.Монгол Улсын Шинжлэх ухааны академийн бүтцэд монгол хэл, түүний хэрэглээ, хөгжлийг судлах, монгол хэлний хэм хэмжээ, үгийн сангийн өөрчлөлттэй холбоотой санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий монгол хэл шинжлэлийн хүрээлэн /цаашид “эрх бүхий судалгааны байгууллага” гэх/ ажиллана.

22.2.Эрх бүхий судалгааны байгууллага дараах үүрэг хүлээнэ:

22.2.1.монгол хэлний зөв бичих дүрэм боловсруулж, түүнд өөрчлөлт оруулах асуудлаар санал дэвшүүлэх;

22.2.2.эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээний бусад байгууллагаас боловсруулсан бичиг үсгийн дүрмийн гарын авлага, монгол хэлний үгийн сангийн болон мэргэжлийн хэлний толь бичиг, бусад холбогдох толь бичиг монгол хэлний зөв бичих дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянаж, дүгнэлт гаргах;

22.2.3.холбогдох мэргэжлийн байгууллагын туслалцаатайгаар гадаад нэр томъёог монгол хэлнээ орчуулах;

22.2.4.газар нутгийн оноосон нэрийг толь бичигт оруулах, жигдлэх, олон улсын газар зүйн нэрийн тольд бүртгүүлэх талаар энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагад санал гаргах;

22.2.5.төрийн албанд анх орох иргэнээс болон гадаадын иргэнээс авах монгол хэлний төвшин тогтоох шалгалтын агуулга боловсруулах ажлыг зохион байгуулах;



22.2.6.монгол хэл, бичгийн зөв бичих дүрэм, хэрэглээтэй холбоотой стандартыг боловсруулж, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д заасны дагуу батлуулах;

22.2.7.нэр томъёоны талаар иргэн, хуулийн этгээдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

23 дугаар зүйл.Монгол хэлний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол хэлний тухай хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол шүүгч, эрх бүхий улсын байцаагч дараах шийтгэл ногдуулна:

23.1.1.энэ хуулийн 6.3, 7.3, 16.1.1, 16.2-т заасныг зөрчсөн хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

24.1.Энэ хуулийг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

24.2.Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАН ЁСНЫ ХЭЛНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2003 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр баталсан Монгол хэлний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд өрийн зохистой түвшинг хангах, дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх, Засгийн газар, орон нутаг зээллэг хийх замаар өр үүсгэх, дамжуулан зээлдүүлэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах, тэдгээрийг бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хууль тогтоомж

2.1.Өрийн удирдлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль², Төсвийн тухай хууль³, Олон улсын гэрээний тухай хууль⁴, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль⁵, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

¹Монгол Улсын Үндсэн хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

²Төсвийн тогтвортой байдлын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

³Төсвийн тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

⁴Олон улсын гэрээний тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

⁵Засгийн газрын тусгай сангийн тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр өр үүсгэх, түүнийг удирдахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хувийн хэвшлийн өр төлбөрийн харилцаанд энэ хууль хамаарахгүй.

3.3.Засгийн газрын өрийн баталгааг энэ хуулиар, төсвийн харилцаанд хамаарах болзошгүй өр төлбөрийн асуудлыг бусад хуулиар зохицуулна.

3.4.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах, түүнийг бүртгэхээс бусад тохиолдолд тухайн хуулийн этгээдийн өр төлбөрийн харилцаанд энэ хууль хамаарахгүй.

3.5.Бүх төрлийн тусламжийн харилцаанд энэ хууль хамаарахгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“өр” гэж өрийн хэрэгслээр дамжуулан тодорхой хугацаанд төлөх хүү, үндсэн төлбөр болон холбогдох бусад төлбөрийн үүргийг;

4.1.2.“өрийн хэрэгсэл” гэж бүх төрлийн зээл, үнэт цаас болон өр үүсгэх аливаа гэрээ, хэлцлийг;

4.1.3.“өрийн удирдлага” гэж Засгийн газрын богино, дунд хугацааны санхүүгийн зардал, эрсдэлийн түвшинг тодорхойлсны үндсэн дээр стратеги боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах, хяналт тавих үйл ажиллагааг;

4.1.4.“улсын нийт гадаад өр” гэж Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээс Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үүргийг;



4.1.5.“улсын төсөв” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.6-д заасныг;

4.1.6.“Засгийн газрын өр” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг;

4.1.7.“Засгийн газрын өрийн баталгаа” гэж баталгаа гаргуулагч нь гэрээнд заасан төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүргийг;

4.1.8.“Засгийн газрын өрийн удирдлагын стратеги” гэж Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг;

4.1.9.“Монгол Улсын мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөхүйц байх” гэж Засгийн газрын зүгээс тухайн үеийн мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний зорилтот үр дүн болон валютын зах зээл дэх төгрөгийн ханшид нөлөөлөх хэмжээ, нөхцөл бүхий үнэт цаас гаргах, гадаад зээллэг хийх, ашиглах, буцаан төлөхийг;

4.1.10.“өрийн бүтэц” гэж өрийг эргэн төлөгдөх хугацаа, нөхцөл, валют болон бусад шинж чанараар нь ангилсныг;

4.1.11.“өрийн үйлчилгээ” гэж тухайн төсвийн жилд хийгдэх өрийн үндсэн болон хүүгийн төлбөр, холбогдох бусад төлбөрийг;

4.1.12.“өрийг дахин санхүүжүүлэх” гэж өрийн үйлчилгээг гүйцэтгэх зорилгоор шинээр зээллэг хийх үйл ажиллагааг;

4.1.13.“өрийн хязгаар” гэж Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд злэх дээд хэмжээг хувьчлан тогтоосныг;

4.1.14.“зээллэг болон өрийн баталгааны дээд хэмжээ” гэж тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр хийх зээллэг, гаргах өрийн баталгааны хэмжээнд Улсын Их Хурлаас мөнгөн хэлбэрээр хязгаар тогтоохыг;

4.1.15.“зээллэг” гэж Засгийн газрын өрийн баталгаанаас бусад өрийн хэрэгслээр дамжуулан өр үүсгэхийг;



4.1.16.“зээллэгийн төлөвлөгөө” гэж Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичигт үндэслэн өрийн хэрэгсэл тус бүрээр гаргасан төлөвлөгөөт хуваарийг;

4.1.17.“гадаад зээл” гэж Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдээс олгосон өр үүсгэх хөрөнгийн эх үүсвэрийг;

4.1.18.“хөнгөлөлтийн түвшин” гэж зээлийн нэрлэсэн үнэ болон өнөөгийн үнэ цэнийн хоорондын зөрүүг тухайн зээлийн нэрлэсэн үнэтэй харьцуулж, хувиар илэрхийлснийг;

4.1.19.“Засгийн газрын үнэт цаас” гэж Засгийн газраас энэ хуульд заасан зориулалт, журмын дагуу арилжаалсан өрийн бичгийг;

4.1.20.“аймаг, нийслэлийн үнэт цаас” гэж аймаг, нийслэлээс энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, зориулалт, журмын дагуу тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй дотоодын зах зээлд арилжаалсан өрийн бичгийг;

4.1.21.“төсөл хэрэгжүүлэгч” гэж гадаад зээллэгийн хөрөнгөөр санхүүжих төслийн хэрэгжилтийг хариуцах чиг үүрэг бүхий олон улсын гэрээ, төслийн баримт бичиг, гэрээнд оролцогч талуудын хооронд байгуулсан бусад тохиролцлын баримт бичигт заасан эрх бүхий байгууллагыг;

4.1.22.“болзошгүй өр төлбөр” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.48-д заасныг;

4.1.23.“төсөл, арга хэмжээ” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.17-д заасныг.

5 дугаар зүйл.Өрийн удирдлагын зарчим

5.1.Өрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

5.1.1.удирдлагын нэгдсэн тогтолцоотой байх;
5.1.2.өрийн зохистой түвшинг хангах;
5.1.3.өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах;

5.1.4.ил тод байдлыг хангах;
5.1.5.хариуцлагатай байх.



6 дугаар зүйл.Өрийн удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх

6.1.Засгийн газрын өрийн удирдлагын харилцаанд оролцогч этгээд нь энэ хуулийн 5.1-д заасан өрийн удирдлагын зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

6.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан удирдлагын нэгдсэн тогтолцоотой байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.2.1.Засгийн газар, орон нутгийн зээллэг, Засгийн газрын өрийн баталгаа нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон Улсын Их Хурлаас баталсан урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;

6.2.2.Засгийн газар, орон нутгийн зээллэг, Засгийн газрын өрийн баталгааг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хянасан байх;

6.2.3.Засгийн газрын зээллэг, Засгийн газрын өрийн баталгааг Улсын Их Хурлаас, орон нутгийн зээллэгийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж байх;

6.2.4.Засгийн газар, орон нутгийн зээллэг, өрийн баталгаа, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах.

6.3.Энэ хуулийн 5.1.2-т заасан өрийн зохистой түвшинг хангах зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.3.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагыг хангасан байх;

6.3.2.Засгийн газрын шинээр үүсгэх өр болон гаргах өрийн баталгаа нь энэ хуулийн 17.1-д заасан дээд хэмжээнд нийцсэн байх;

6.3.3.Засгийн газар болон орон нутгийн зээллэг, Засгийн газрын өрийн баталгаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр нөлөө нь ирээдүйд өрийн дарамт учруулахгүй байх;

6.3.4.урт хугацаанд Засгийн газрын өрийн зохистой түвшинг хангах замаар Засгийн газрын өрийн удирдлагыг хэрэгжүүлэх.

6.4.Энэ хуулийн 5.1.3-т заасан өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:



6.4.1.Засгийн газрын өрийн баталгаа гаргах болон Засгийн газар, орон нутгийн зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь энэ хуулийн 7.1.6, 35.4-т зааснаас бусад тохиолдолд нийгмийн үр өгөөжтэй, эдийн засгийн үр ашигтай байх;

6.4.2.энэ хуульд өөрөөр заагаагүй бол арилжааны нөхцөлтэй гадаад зээллэгийн эх үүсвэрээр эргэн төлөгдөх чадвартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;

6.4.3.тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа нь түүнийг санхүүжүүлэх зээллэгийн эргэн төлөх хугацаанаас илүүгүй байх чиглэл баримтлах;

6.4.4.гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэл баримтлах;

6.4.5.хууль болон олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол өр үүсгэж бий болгосон хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль⁶-аар зохицуулах.

6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан ил тод байдлыг хангах зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.5.1.хуульд өөрөөр заагаагүй бол улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны талаар тогтоосон хугацаанд олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;

6.5.2.Засгийн газар болон орон нутгийн зээллэг, өр төлбөр, Засгийн газрын өрийн баталгаа, болзошгүй өр төлбөр нийтэд ил тод байх.

6.6.Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.6.1.өрийн удирдлагын талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг хуульд заасны дагуу хэрэгжүүлэх, хуулийн шаардлага, хэм хэмжээг зөрчихгүй байх, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх;

⁶Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2005 оны 48 дугаарт нийтлэгдсэн.



6.6.2.энэ хуульд заасны дагуу өр үүсгэж байгаа аливаа этгээд нь зээллэгийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай ашиглах, төсвийн сахилга батыг сахих;

6.6.3.энэ хуульд заасны дагуу өр үүсгэж байгаа аливаа этгээд нь өр төлбөрийн үүргээ хууль болон гэрээнд заасны дагуу хугацаанд нь төлж барагдуулах, санхүүгийн хариуцлагатай байх;

6.6.4.энэ хуулийг зөрчиж өр үүсгэх замаар эх үүсвэр бүрдүүлэхгүй байх;

6.6.5.холбогдох этгээд нь Засгийн газрын өрийн баталгаа гаргасан болон өр үүсгэж бий болгосон хөрөнгө, түүгээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг энэ хуульд заасны дагуу гаргаж тайлагнах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ӨРИЙН УДИРДЛАГЫН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ

7 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

7.1.Улсын Их Хурал өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.төсөв, мөнгөний бодлогын хүрээнд Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг /цаашид "стратегийн баримт бичиг" гэх/-ийг батлах;

7.1.2.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон стратегийн баримт бичигт үндэслэн тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг төсвийн хамт батлах;

7.1.3.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон стратегийн баримт бичигт үндэслэн тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр гаргах өрийн баталгааны дээд хэмжээг тогтоох;

7.1.4.Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

7.1.5.Засгийн газрын гадаад зээлийн гэрээг соёрхон батлах;



7.1.6.нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх чадваргүй төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр санхүүжүүлэх эсэхийг тухайн жилийн төсвийн хуулиар, шаардлагатай тохиолдолд тухай бүр шийдвэрлэх;

7.1.7.зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт хэлэлцэх, хэрэгжилттэй холбогдуулан чиглэл өгөх;

7.1.8.стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг хэлэлцэх, өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

8.1.Засгийн газар өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг энэ хуульд заасны дагуу тодорхойлж, стратегийн баримт бичгийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

8.1.2.стратегийн баримт бичигт үндэслэн тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг төсвийн төслийн хамт, Засгийн газрын шинээр гаргах өрийн баталгааны дээд хэмжээг тусад нь боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

8.1.3.Олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу Улсын Их Хуралтай зөвшилцсөний үндсэн дээр зээлийн гэрээнд гарын үсэг зурах эрх олгох;

8.1.4.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу зээллэг хийх, өрийн баталгаа гаргах асуудлыг шийдвэрлэх;

8.1.5.өр үүсгэж бий болгосон хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн талаар ирүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланг хэлэлцэх, дүгнэх, чиглэл өгөх;

8.1.6.стратегийн баримт бичиг болон зээллэгийн дээд хэмжээнд үндэслэн тухайн төсвийн жилийн зээллэгийн төлөвлөгөөг батлах;



8.1.7.өр үүсгэж бий болгосон хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнгийн талаар Улсын Их Хуралд тайлагнах, өгөгдсөн чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авах;

8.1.8.өрийн удирдлагын тухай хууль тогтоомж болон стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, үр дүнг Улсын Их Хуралд тайлагнах;

8.1.9.аймаг, нийслэлийн хийх зээллэгт зөвшөөрөл олгох;

8.1.10.Засгийн газрын өрийн удирдлагын асуудлаар энэ хуульд заасан журмыг батлах;

8.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

8.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.2.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон стратегийн баримт бичигт үндэслэн тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өр, гаргах өрийн баталгааны дээд хэмжээг Засгийн газарт хэлэлцүүлэх;

8.2.2.Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг байгуулах;

8.2.3.Засгийн газрын зөвшөөрснөөр Засгийн газрын өрийн баталгааны болон авлага барагдуулах гэрээг байгуулах;

8.2.4.Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг тогтоох, арилжаа болон төлбөрийн хуваарийг батлах;

8.2.5.Засгийн газрын өрийн удирдлагын асуудлаар энэ хуульд заасан журмыг батлах;

8.2.6.энэ хуулийн 21.1-д заасны дагуу Өрийн удирдлагын зөвлөлийг байгуулах;

8.2.7.Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээний саналыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;



8.2.8.гадаад зээлийн гэрээний хэлэлцээг хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Засгийн газраас эрх олгосноор гадаад зээлийн гэрээнд гарын үсэг зурах;

8.2.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.стратегийн баримт бичгийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн энэ хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу боловсруулах;

9.1.2.Засгийн газрын өрийн удирдлагын бодлого, зохицуулалтыг энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлэх;

9.1.3.стратегийн баримт бичигт үндэслэн тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг тооцоолж төсвийн төсөлд тусгах;

9.1.4.стратегийн баримт бичигт үндэслэн тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр гаргах өрийн баталгааны дээд хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг боловсруулах;

9.1.5.Засгийн газрын гадаад, дотоод өрийн үйлчилгээний хуваарийг гаргаж, улсын төсөвт учруулж болох дарамт, нөлөөллийг тооцох, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах;

9.1.6.стратегийн баримт бичигт үндэслэн Засгийн газрын зээллэгийн төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;

9.1.7.Засгийн газрын зээллэгийн хөрөнгө, өрийн баталгааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах талаар шаардлагатай арга хэмжээг авах;

9.1.8.Засгийн газар, орон нутаг өр үүсгэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах аливаа шийдвэрийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаар болон хуульд



заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг хянаж, санал, дүгнэлт гаргах;

9.1.9.Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах;

9.1.10.эрсдэлийн үнэлгээгээр тухайн зээллэгийн хөрөнгийг хугацаандаа бүрэн төлөх нь батлагдсан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр Засгийн газрыг төлөөлж дамжуулан зээлдүүлэх;

9.1.11.дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;

9.1.12.энэ хуулийн 7.1.2-т заасныг үндэслэн Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах, Засгийн газрын үнэт цаас гаргагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх;

9.1.13.Засгийн газрын өрийн баталгааны санг байгуулах;

9.1.14.Засгийн газрын өрийн үлдэгдлийг улирал тутам, дунд хугацааны өрийн үйлчилгээний төсөөллийг жил бүр тооцоолж гаргах;

9.1.15.улсын нийт гадаад өрийн үлдэгдлийг улирал тутам Монголбанктай хамтран гаргах;

9.1.16.энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг төрийн байгууллага, холбогдох бусад этгээдээс гаргуулж авах;

9.1.17.гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх санал боловсруулах;

9.1.18.Засгийн газрын өрийн удирдлагын асуудлаар энэ хуульд заасан журмыг боловсруулах;

9.1.19.дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулах;

9.1.20.Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс олон улсын байгууллага, түнш оронд Засгийн газрын гадаад зээл авах хүсэлтийг албан ёсоор тавих, гадаад зээлийн хэлэлцээг хийх, гэрээ байгуулах, зохицуулах, хяналт тавих;



9.1.21.Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах, үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулах;

9.1.22.хуульд заасан бусад бүрэн эрх.

9.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд заасан өрийн удирдлагын бодлого, зохицуулалт болон төлөвлөлт, судалгаа шинжилгээ, өрийн үйлчилгээ, бүртгэл, мэдээллийн асуудал эрхэлсэн өрийн удирдлагын нэгжтэй байна.

9.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн Засгийн газрын зээллэгийн хөрөнгө, өрийн баталгааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хянаж, Төсвийн тухай хуульд заасны дагуу эрэмбэлж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган Засгийн газарт хүргүүлнэ.

10 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

10.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.өрийн удирдлагын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналт тавих;

10.1.2.орон нутгийн хэмжээнд зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Засаг даргын өргөн мэдүүлснээр хэлэлцэн батлах;

10.1.3.тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт хэлэлцэх, хэрэгжилттэй холбогдуулан чиглэл өгөх;

10.1.4.орон нутгийн өр үүсгэх Засаг даргын саналыг хэлэлцэх, Засгийн газрын зөвшөөрөлд үндэслэн орон нутгийн зээллэг хийх шийдвэр гаргах;

10.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

10.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



10.2.1.орон нутгийн хэмжээнд зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, энэ хуулийн 19.1-д заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

10.2.2.тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих;

10.2.3.энэ хуульд заасны дагуу аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, зээлийн гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулах;

10.2.4.тухайн орон нутагт гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар холбогдох тооцоо, судалгааны хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

10.2.5.гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн дотоодын эх үүсвэрийн хэмжээг жил бүрийн төсвийн төсөлд тусгуулах;

10.2.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл.Өрийн удирдлагын талаар төрийн бусад байгууллагын чиг үүрэг

11.1.Монголбанк өрийн удирдлагын хүрээнд дараах чиг үүрэгтэй:

11.1.1.улсын нийт гадаад өрийн үлдэгдлийг улирал тутам санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гаргаж, олон нийтэд мэдээлэх;

11.1.2.Засгийн газрын хийх зээллэгийн хэмжээ нь Монгол Улсын мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөхүйц байх тохиолдолд тухай бүр холбогдох санал зөвлөмжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

11.2.Төрийн аудитын төв байгууллага өрийн удирдлагын хүрээнд дараах чиг үүрэгтэй:

11.2.1.энэ хуульд заасны дагуу стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд аудит хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх;

11.2.2.өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх;



11.2.3.энэ хуулийн 9.1.9-д заасан эрсдэлийн үнэлгээнд тухай бүр хөндлөнгийн аудит хийж, дүгнэлт гаргах;

11.2.4.энэ хуулийн 37.2-т заасны дагуу дүгнэлт гаргах.

11.3.Үндэсний статистикийн хороо нь улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон өрийн баталгааны талаарх мэдээллийг макро эдийн засгийн тойм мэдээнд хамаарах тоон дүн, статистик мэдээллийн хамт улирал, жилээр нэгтгэн гаргах чиг үүрэгтэй.

11.4.Аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нь өрийн удирдлагын хүрээнд дараах чиг үүрэгтэй:

11.4.1.Засгийн газрын зээллэгийн хөрөнгө, Засгийн газрын өрийн баталгааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар холбогдох тооцоо, судалгааны хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

11.4.2.өр үүсгэж бий болгосон хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн тайланг Засгийн газарт танилцуулах;

11.4.3.Засгийн газрын зээллэгийн хөрөнгө, Засгийн газрын өрийн баталгааны хүрээнд хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

11.4.4.гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн дотоод эх үүсвэрийн хэмжээг жил бүрийн төсвийн төсөлд тусгуулах;

11.4.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

12 дугаар зүйл.Өр үүсгэх зориулалт

12.1.Засгийн газар дараах зориулалтаар өр үүсгэж болно:

12.1.1.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх;

12.1.2.төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх;



12.1.3.Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих;

12.1.4.өрийг дахин санхүүжүүлэх;

12.1.5.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх;

12.1.6.улсын төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор Монголбанкны гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.

12.2.Өрийг дахин санхүүжүүлэхдээ төсвийн дарамт, ачааллыг жигдлэх болон зах зээлийн эрсдэлийг бууруулах чиглэлийг баримтална.

12.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 19, 28 дугаар зүйлд заасныг баримтлан төсөвт туссаны үндсэн дээр Засгийн газраас зөвшөөрснөөр өр үүсгэж болно.

13 дугаар зүйл.Засгийн газрын өрийн удирдлага, түүнийг хэрэгжүүлэх

13.1.Өрийн удирдлагын бодлого, стратеги нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд, хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжихэд чиглэнэ.

13.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын өрийн удирдлагыг стратегийн баримт бичгийн хүрээнд дараах байдлаар хэрэгжүүлнэ:

13.2.1.Засгийн газрын санхүүгийн хэрэгцээ, өрийн багц дахь зардал, эрсдэлийн шинжилгээнд үндэслэн өрийн удирдлагын стратеги боловсруулж, хэрэгжүүлэх;

13.2.2.Засгийн газрын өрийн удирдлагын зорилт, өрийн хэмжээ, өрийн багцын бүтэц, эрсдэлийг богино, дунд хугацаагаар оновчтой тодорхойлж, удирдан зохицуулах;

13.2.3.тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өр, түүнд тавих шаардлага, нөхцөл, хязгаарлалтыг энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлэх;

13.2.4.улсын нийт гадаад өрийн мэдээллийн санг Монголбанкт хамтран хөтөлж, энэ хуульд заасны дагуу нийтэд мэдээлж, Засгийн газрын өрийн мэдээллийн ил тод байдлыг хангах.



14 дүгээр зүйл. Стратегийн баримт бичиг

14.1. Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратеги нь бодлогын баримт бичгээр тодорхойлогдох ба энэ хуулийн 13.1-д заасныг баримтална.

14.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн баримт бичгийг боловсруулж, тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт гурван жилд нэг удаа Төсвийн тухай хуулийн 8.1-д заасан цаглабрын дагуу батлуулна.

14.3. Стратегийн баримт бичигт дараах зүйлийг тусгана:

14.3.1. улсын нийт гадаад өр, Засгийн газрын өрийн тухайн үеийн нөхцөл байдал;

14.3.2. Засгийн газрын өрийн шалгуур үзүүлэлтийн дунд хугацааны төсөөлөл;

14.3.3. санхүүжилтийн боломжит эх үүсвэр;

14.3.4. Засгийн газрын өрийн багцад дунд хугацаанд нөлөөлөх хүчин зүйлс;

14.3.5. Засгийн газрын өрийн багц дахь зардал, эрсдэлд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн таамаглал;

14.3.6. Засгийн газрын өрийн баталгааны багцын тухайн үеийн нөхцөл байдал, өрийн багц дахь зардал, эрсдэлд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн таамаглал;

14.3.7. Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтот бүтэц;

14.3.8. өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга зам, өрийн зохицуулалтын үйл ажиллагаа;

14.3.9. бусад.

14.4. Макро эдийн засгийн голлох үзүүлэлтийн хэлбэлзлээс шалтгаалан дунд хугацааны төсөөлөлд суурилсан өрийн багцын зорилтот түвшинд хүрэх боломжгүй болсноос бусад тохиолдолд стратегийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.



14.5.Энэ хуулийн 14.4, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Засгийн газраас стратегийн баримт бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусган тухай бүр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулна.

14.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 14.2-т заасны дагуу стратегийн баримт бичгийг өмнөх стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлангийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

15 дугаар зүйл.Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт тавих

15.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнана:

15.1.1.Стратегийн баримт бичгийн явцын тайланг жил бүр гаргаж, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт Засгийн газарт хүргүүлэх;

15.1.2.Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг гурван жилд нэг удаа гаргаж, энэ хуульд заасны дагуу Улсын Их Хуралд хүргүүлэх.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан тайланд дараах зүйлийг тусгана:

15.2.1.улсын нийт гадаад өр, Засгийн газрын өрийн талаарх мэдээлэл;

15.2.2.Засгийн газрын өрийн багц дахь зардал, эрсдэлийн шинжилгээ, түүний тайлбар;

15.2.3.Засгийн газрын өрийн багцын дунд хугацааны зорилтот бүтэц, түүний хэрэгжилт;

15.2.4.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаарыг хангасан байдал;

15.2.5.зээллэгийн төлөвлөгөөний хэрэгжилт;

15.2.6.бусад.

15.3.Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг 03 дугаар сарын 01-ний дотор гаргаж төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх ба уг тайланд төрийн аудитын төв байгууллага 04 дүгээр сарын 01-ний дотор аудит хийнэ.



15.4.Засгийн газар стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг гурван жилд нэг удаа төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийн хамтаар дараагийн стратегийн баримт бичгийн төсөл өргөн мэдүүлэх хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, тайлагнана.

15.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага стратегийн баримт бичиг, түүний хэрэгжилтийн тайланг нийтэд мэдээлнэ.

16 дугаар зүйл.Засгийн газрын өрийн хязгаар

16.1.Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагад нийцсэн байна.

16.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газар, орон нутаг өр үүсгэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах аливаа шийдвэрийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаарт болон хуульд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг хянаж, санал, дүгнэлт гаргана.

16.3.Засгийн газар, орон нутаг зээллэг хийх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд энэ хуулийн 16.2-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын уг асуудлаар гаргасан санал, дүгнэлтийн хамт хэлэлцэж, шийдвэрлэнэ.

17 дугаар зүйл.Засгийн газрын шинээр үүсгэх өр болон гаргах өрийн баталгааны дээд хэмжээг тогтоох

17.1.Тухайн төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулан жил бүрийн төсвийн хуулийн хамт батлах ба Засгийн газрын өрийн баталгааны дээд хэмжээг Улсын Их Хурал батална.

17.2.Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагад нийцсэн байна.

17.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 17.2-т заасныг үндэслэн Засгийн газрын тухайн жилд шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг шинэчлэн боловсруулж, төсвийн төсөлд тусган Засгийн газарт хүргүүлнэ.



17.4.Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээний дүнд зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг оруулж тооцсон байна.

18 дугаар зүйл.Засгийн газар зээллэг хийх

18.1.Засгийн газар энэ хуулийн 12.1, 16.1, 17.1-д заасныг үндэслэн стратегийн баримт бичигт нийцүүлэн зээллэг хийж болно.

18.2.Засгийн газар зээллэг хийхдээ дараах шаардлагыг хангана:

18.2.1.тухайн төсвийн жилийн зээллэгийн төлөвлөгөө, зээллэгийн дээд хэмжээнд нийцсэн байх;

18.2.2.энэ хуулийн 16.2-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг авсан байх;

18.2.3.Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагыг хангасан байх.

18.3.Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу зохицуулна.

18.4.Засгийн газар Монгол Улсын мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөхүйц зээллэг хийх тохиолдолд уг зээллэгийн хэмжээ, нөхцөл, хугацааг Монголбанкттай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

18.5.Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна:

18.5.1.төсөвт тусгагдсан байх;

18.5.2.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх;

18.5.3.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан байх;

18.5.4.тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан байх;



18.5.5.гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлж байгаа тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээ эдийн засгийн үр ашигтай, зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон байх;

18.5.6.гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлж байгаа тохиолдолд уг гэрээний хугацаа нь үндсэн зээлийн гэрээний хугацаанаас илүүгүй байх;

18.5.7.тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийгдэж, баталгаажуулсан байх.

18.6.Засгийн газрын шинээр хийх зээллэг нь энэ хуулийн 18.5.3, 18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санал, дүгнэлт гаргана.

18.7.Засгийн газар нь Монголбанкнаас энэ хуулийн 12.1.2-т заасан зорилгоор тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээллэг хийж болно.

18.8.Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдох бөгөөд уг гэрээгээр санхүүжих төсөл, арга хэмжээ нь энэ хуулийн 18.5.1-18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангасан байна.

18.9.Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг байгуулахад энэ хуулийн 16.2-т заасныг удирдлага болгоно.

18.10.Засгийн газар энэ хуулийн 18.7-д заасныг зөрчиж Монголбанкнаас зээллэг хийхийг хориглоно.

19 дүгээр зүйл.Орон нутгийн өрийн удирдлага, зохицуулалт

19.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 6.2.2, 7.1.2, 8.1.4-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, Засгийн газраас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээллэг хийх бөгөөд зээллэг хийх шийдвэрийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

19.2.Аймаг, нийслэлийн Засаг даргын улсын төсвөөс тухайн төсвийн жилийн дотор эргэн төлөгдөх нөхцөлтэй өр үүсгэх асуудлыг Төсвийн тухай хуульд зааснаар зохицуулна.



19.3. Дараах шаардлагыг хангасан аймаг, нийслэл нь Төсвийн тухай хуулийн 58.1, 58.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төслийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно:

19.3.1. улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авдаггүй байх;

19.3.2. тухайн орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зардлынхаа 50 хувиас багагүй байх.

19.4. Энэ хуулийн 19.3-т заасны дагуу үүсгэх орон нутгийн өрийн үлдэгдлийн хэмжээ нь тухайн аймаг, нийслэлийн өмнөх гурван жилийн төсвийн дундаж суурь орлогын 50 хувиас, тухайн төсвийн жилд төлөх өрийн үйлчилгээний хэмжээ нь суурь зардлын 50 хувиас илүүгүй байна.

19.5. Энэ хуулийн 19.3-т заасны дагуу үүсгэсэн өрийн үйлчилгээг тухайн орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх дүнгээр төсөвт нь үлдээсэн хөрөнгийн эх үүсвэрээс төлнө.

19.6. Аймаг, нийслэлийн төсөвт энэ хуулийн 19.3-т заасны дагуу өр үүсгэхдээ дараах хөрөнгө, орлогыг өрийн барьцаа болгох, өрийн үйлчилгээг санхүүжүүлэхийг хориглоно:

19.6.1. Төсвийн тухай хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамаарах аймаг, нийслэлийн өмчийн эд хөрөнгө;

19.6.2. аймаг, нийслэлийн төсвийн бүх төрлийн орлого;

19.6.3. улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг;

19.6.4. улсын төсвийн орлогын шилжүүлэг.

19.7. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасны дагуу өр үүсгэхдээ дараах шаардлагыг хангана:

19.7.1. өр үүсгэх эх үүсвэр нь энэ хуулийн 17.1, 19.4-т заасан шаардлагад нийцсэн байх;

19.7.2. өр үүсгэн санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн асуудал болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянагдсан байх;

19.7.3. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянагдсан байх;

19.7.4. Засгийн газраас зөвшөөрөл авч, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;



19.7.5.өрийн зориулалтыг нийтэд мэдээлэх, шаардлагатай бол олон нийтийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж хэлэлцүүлэх.

19.8.Аймаг, нийслэлийн Засаг дарга өр үүсгэх аливаа гэрээнд гарын үсэг зурсан болон үнэт цаас арилжаалснаас хойш ажлын 10 өдрийн дотор гэрээний хуулбар, холбогдох баримт бичиг, мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

19.9.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуульд зааснаар тодорхойлогдох тухайн орон нутгийн өмнөх улирлын өрийн үлдэгдэл болон хугацаа хэтэрсэн өр, түүнд ногдох хүү, алданги торгуулийн талаарх мэдээллийг дараа улирлын эхний сарын 10-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

19.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн орон нутагт хамаарах зээллэг, өртэй холбогдолтой аливаа мэдээллийг шаардсан тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга уг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох мэдээллийг хүргүүлнэ.

19.11.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуульд зааснаас бусад тохиолдолд орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр өр үүсгэх, баталгаа гаргахыг хориглоно.

19.12.Аймаг, нийслэлийн өрийн үйлчилгээг тухайн орон нутгийн төсвөөс гүйцэтгэнэ.

19.13.Энэ хуулийн 19.11-д аймаг, нийслэлийн Засаг даргын тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх төсвийн зээл хамаарахгүй.

20 дугаар зүйл.Засгийн газрын өрийн зохицуулалтын үйл ажиллагаа

20.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өрийн багцын оновчтой бүтцийг бий болгох, эрсдэлийг зохистой удирдах зорилгоор стратегийн баримт бичигт тусгасан өрийн зохицуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно:

- 20.1.1.валютын болон хүүгийн своп /солилцоо/ хийх;
- 20.1.2.валютын форвард хэлцэлд орох;
- 20.1.3.өрийг дахин санхүүжүүлэх, шилжүүлэх болон худалдах;



- 20.1.4.өрийг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах;
- 20.1.5.бусад.

21 дүгээр зүйл.Өрийн удирдлагын зөвлөл

21.1.Өрийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус Өрийн удирдлагын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.

21.2.Зөвлөл нь дараах асуудлаар зөвлөмж гаргана:

- 21.2.1.Засгийн газрын өрийн удирдлагын бодлого;
- 21.2.2.стратегийн баримт бичгийн төсөл;
- 21.2.3.стратегийн баримт бичгийн хэрэгжилт;

21.2.4.өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл;

21.2.5.Засгийн газрын өрийн зохицуулалтын үйл ажиллагаа.

21.3.Зөвлөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдах бөгөөд Зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газраас батална.

21.4.Зөвлөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон санхүү, эдийн засгийн салбарын мэргэшсэн судлаачдын төлөөллийг оролцуулан есөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд байгуулна.

22 дугаар зүйл.Засгийн газрын өрийн үйлчилгээ

22.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн үйлчилгээг тогтоосон хугацаанд нь бүрэн гүйцэтгэнэ.

22.2.Засгийн газрын өрийн үйлчилгээний журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мөрдүүлнэ.



**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ӨР ҮҮСГЭХ БОЛОН ӨРИЙН УДИРДЛАГЫН
ХЭРЭГЖИЛТ**

**НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ
ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ**

**23 дугаар зүйл.Засгийн газрын гадаад зээл, түүнд
тавигдах шаардлага**

23.1.Засгийн газрын гадаад зээл нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан байх бөгөөд дараах төрөлтэй байна:

23.1.1.арилжааны буюу 15 хүртэлх хувийн хөнгөлөлтийн түвшинтэй зээл;

23.1.2.хөнгөлөлттэй буюу 15-35 хүртэлх хувийн хөнгөлөлтийн түвшинтэй зээл;

23.1.3.нэн хөнгөлөлттэй буюу 35 болон түүнээс дээш хувийн хөнгөлөлтийн түвшинтэй зээл.

23.2.Засгийн газрын арилжааны нөхцөлтэй гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь энэ хуулийн 18.5-д заасан шаардлагыг хангасан байна.

23.3.Засгийн газрын хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна:

23.3.1.энэ хуулийн 18.5.1-18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангасан байх;

23.3.2.олон улсын байгууллага, түнш оронтой гэрээ байгуулах, хэлэлцээр хийхэд Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг харгалзсан байх;

23.3.3.төсөл, арга хэмжээний Засгийн газраас санхүүжүүлэх дүнд дараах зүйлийг оруулан тооцсон байх:

23.3.3.а.шууд санхүүжилт буюу бараа, ажил, үйлчилгээний төлбөр;



23.3.3.б.шууд бус санхүүжилт буюу татвар, төлбөр, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт болон төсөл, арга хэмжээний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бусад дэмжлэг.

23.4.Засгийн газрын гадаад зээлийн гэрээ, хэлэлцээр байгуулагдсаны үндсэн дээр тухайн төсөл, арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусгана.

23.5.Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу авах Засгийн газрын гадаад зээлийн гэрээ, хэлэлцээр тухайн төсвийн жилийн дундуур байгуулагдсан бол уг зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 47.1.2-т заасныг үндэслэн нэмэлт төсөвт тусгана.

24 дүгээр зүйл.Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн ашиглалт

24.1.Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зорилго, нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашиг, эргэн төлөгдөх чадвараас нь хамааруулж эх үүсвэрийг дараах хэлбэрээр ашиглана:

24.1.1.төсөл хэрэгжүүлэх гэрээний үндсэн дээр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр санхүүжүүлэх;

24.1.2.дамжуулан зээлдүүлэх;

24.1.3.Засгийн газар, яамд, тэдгээрийн харьяа байгууллагын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх.

24.2.Нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх чадваргүй төсөл, арга хэмжээг нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх чиглэл баримтлах ба санхүүжүүлэх боломжгүй тохиолдолд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.

24.3.Энэ хуулийн 7.1.6-д зааснаас бусад тохиолдолд Засгийн газрын арилжааны нөхцөлтэй гадаад зээлийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үндсэн дээр ашиглана.

24.4.Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мөрдүүлнэ.



24.5.Энэ хуулийн 24.1.1-д заасан төсөл хэрэгжүүлэх гэрээний хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль⁷-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэнэ.

25 дугаар зүйл.Гадаад зээл авах, гэрээ байгуулах

25.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт үндэслэн гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг зээлдүүлэгч талд тавьж, хэлэлцээр хийнэ.

25.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 25.1-д заасан хэлэлцээр хийхдээ холбогдох салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа агентлаг, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн бусад байгууллагыг оролцуулна.

25.3.Засгийн газар нь тусгайлан эрх олгосноос бусад тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гадаад зээлийн гэрээг байгуулна.

25.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад эх үүсвэрээс зээл авах, зээлийн гэрээ байгуулах эрх хэмжээг хэрэгжүүлэхэд дараах шаардлагыг хангана:

25.4.1.гадаад эх үүсвэрээс авах зээлийн хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тухайн төсвийн жилийн зээллэгийн дээд хэмжээ болон зээллэгийн төлөвлөгөөнд нийцсэн байх;

25.4.2.энэ хуулийн 16.2-т заасан санал, дүгнэлтийг авсан байх;

25.4.3.тухайн төсөл, арга хэмжээ хэрэгжих салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байх.

25.5.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 25.4.3-т заасан саналыг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, энэ хуулийн 18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангасан байна.

⁷Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн



25.6.Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан гадаад зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тусгайлсан болон санхүүжилтийн гэрээ, хэлэлцээрийг хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газар холбогдох этгээдтэй шууд байгуулж болно.

25.7.Гадаад зээлийн гэрээ, хэлэлцээр байгуулсан тухай бүр уг гэрээ, хэлэлцээрийн хувийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

25.8.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчиж гадаад эх үүсвэрээс зээл авах, зээлийн гэрээ байгуулахыг хориглоно.

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ҮНЭТ ЦААС

26 дугаар зүйл.Засгийн газрын үнэт цаас гаргах

26.1.Засгийн газрын дотоод үнэт цаасыг энэ хуулийн 12.1.1-12.1.4, гадаад үнэт цаасыг энэ хуулийн 12.1.1, 12.1.4-12.1.6-д заасан зориулалтаар гаргана.

26.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын үнэт цаас гаргагчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

26.3.Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргахтай холбогдсон аливаа шийдвэрийн төслийг энэ хуулийн 8.2.4-т заасныг үндэслэн Засгийн газарт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд Засгийн газар оруулна.

26.4.Засгийн газрын үнэт цаас гаргахад дараах шаардлагыг хангасан байна:

26.4.1.тухайн жилийн төсвийн хуульд тусгасан байх;

26.4.2.гаргах үнэт цаасны үнийн дүн нь энэ хуульд заасны дагуу тухайн төсвийн жилийн зээллэгийн дээд хэмжээнд нийцсэн байх;

26.4.3.стратегийн баримт бичигт нийцсэн байх.

26.5.Засгийн газрын тухайн төсвийн жилд арилжаалах дотоод үнэт цаасны хуваарийг зээллэгийн төлөвлөгөө болон стратегийн баримт бичигт нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



26.6.Засгийн газрын үнэт цаас гаргах хуваарьт дараах шаардлагыг тусгана:

26.6.1.үнэт цаасны төрөл, нөхцөл, хэмжээ;

26.6.2.үнэт цаас арилжаалах хэлбэр;

26.6.3.үнэт цаасны арилжааны болон төлбөр тооцооны он, сар, өдөр.

26.7.Засгийн газрын үнэт цаас гаргахтай холбогдсон зардлыг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

26.8.Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгийг энэ хуулийн 18.5-д заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үндсэн дээр ашиглана.

26.9.Засгийн газрын гадаад үнэт цаасыг энэ хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар гаргах санаачилгыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

26.10.Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны болон Засгийн газрын гадаад үнэт цаасыг гаргах, арилжаалах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулж, Засгийн газар баталж, мөрдүүлнэ.

26.11.Үнэт цаас гаргагч нь тухайн төсвийн жилд арилжаалах Засгийн газрын дотоод үнэт цаасны хуваарийг бэлтгэн баталж, олон нийтэд мэдээлнэ.

26.12.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчиж Засгийн газрын үнэт цаас гаргахыг хориглоно.

27 дугаар зүйл.Засгийн газрын үнэт цаасны төрөл

27.1.Засгийн газрын үнэт цаасыг доор дурдсанаар ангилна:

27.1.1.нэг хүртэлх жилийн хугацаанд эргэн төлөгдөх богино хугацаат үнэт цаас;

27.1.2.нэгээс тав хүртэлх жилийн хугацаанд эргэн төлөгдөх дунд хугацаат үнэт цаас;

27.1.3.таваас дээш жилийн хугацаанд эргэн төлөгдөх урт хугацаат үнэт цаас.



28 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах

28.1. Энэ хуулийн 19.3.1, 19.3.2-т заасан шалгуурыг хангасан аймаг, нийслэл нь тухайн орон нутгийн улирлын шинж чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зориулалтаар тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр аймаг, нийслэлийн үнэт цаас гаргаж болно.

28.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь аймаг, нийслэлийн үнэт цаас гаргагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх ба аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

28.3. Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргахад энэ хуулийн 19.1-д заасныг удирдлага болгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

28.3.1. Засгийн газраас үнэт цаас гаргах тухай зөвшөөрөл авсан байх;

28.3.2. Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээнд нийцсэн байх;

28.3.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах санаачилгыг дэмжсэн байх.

28.4. Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах шийдвэрийн төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт оруулах ба Засгийн газар аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах эсэхийг шийдвэрлэнэ.

28.5. Энэ хуулийн 28.4-т заасан Засгийн газрын зөвшөөрөлд үндэслэн аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах шийдвэрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батална.

28.6. Аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбоотой журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулж, Засгийн газар баталж мөрдүүлнэ.

28.7. Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргахтай холбогдсон зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

28.8. Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчиж аймаг, нийслэлийн үнэт цаас гаргахыг хориглоно.



ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЗЭЭЛ

29 дүгээр зүйл. Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээл, түүнд тавигдах шаардлага

29.1. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлж болно.

29.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчтэй байгуулсан дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг үндэслэн зээлийн хөрөнгийг олгоно.

29.3. Дэд зээлдэгч гэдэгт энэ хуульд заасны дагуу дамжуулан зээлдүүлсэн зээлийг эцсийн зээлдэгчид дамжуулан олгож байгаа төсвийн ерөнхийлөн захирагч, Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банк /цаашид “Хөгжлийн банк” гэх/, арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагыг ойлгоно.

29.4. Эцсийн зээлдэгч гэдэгт энэ хуульд заасны дагуу дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үндсэн дээр зээлийн хөрөнгийг, хүүгийн хамт эргэн төлөх нөхцөлтэйгөөр авч байгаа Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийг ойлгоно.

29.5. Засгийн газрын зээллэгийн хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан эцсийн зээлдэгчид зээлдүүлэх тохиолдолд энэ хуулийн 18.5.1-18.5.6, 23.3.3-т заасан шаардлагыг удирдлага болгоно.

29.6. Засгийн газрын зээллэгийн хөрөнгийг дэд зээлдэгч буюу Монголбанк, Хөгжлийн банк, арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагаар дамжуулан эцсийн зээлдэгчид зээлдүүлэх тохиолдолд энэ хуулийн 18.5.1-18.5.3, 18.5.5-18.5.7-д заасан шаардлагыг удирдлага болгоно.

29.7. Энэ хуулийн 29.6-д заасан дэд зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах, үр нөлөөг үнэлэх асуудлыг бие даан шийдвэрлэх ба үүнтэй холбогдож үүсэх эрсдэлийг бүрэн хариуцна.

29.8. Засгийн газрын зээллэгийн хөрөнгийг Хөгжлийн банкинд дамжуулан зээлдүүлэх харилцааг энэ хуулиар, Хөгжлийн банкнаас уг



дамжуулан зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг ашиглах харилцааг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль⁸-д заасны дагуу зохицуулна.

29.9.Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар баталж, мөрдүүлнэ.

29.10.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчиж дамжуулан зээлдүүлэхийг хориглоно.

30 дугаар зүйл. Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулах

30.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг байгуулах бөгөөд уг гэрээний хугацаа нь үндсэн зээлийн гэрээний хугацаанаас илүүгүй байна.

30.2.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлэх тохиолдолд тухайн салбар, эсхүл орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь дэд зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гурвалсан гэрээ байгуулна.

30.3.Энэ хуулийн 30.2-т заасан төсөл, арга хэмжээг Хөгжлийн банкаар санхүүжүүлэхээр Засгийн газраас шийдвэрлэсэн тохиолдолд Хөгжлийн банк нь дэд зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гурвалсан гэрээ байгуулна.

30.4.Арилжааны банк, бусад санхүүгийн байгууллагаар, эсхүл энэ хуулийн 30.3-т зааснаас бусад тохиолдолд Хөгжлийн банкаар дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ нь дараах шатлалаар хийгдэнэ:

30.4.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөгжлийн банк, арилжааны банк, эсхүл бусад санхүүгийн байгууллагын хооронд дамжуулан зээлдүүлэх зээлийн хоёр талт гэрээг байгуулна;

30.4.2.Хөгжлийн банк, арилжааны банк, эсхүл бусад санхүүгийн байгууллага нь эцсийн зээлдэгчтэй дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг байгуулна.

⁸Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль -Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2011 оны 09 дүгээрт нийтлэгдсэн



30.5.Энэ хуулийн 30.4.2-т заасны дагуу байгуулагдсан дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ, түүний хэрэгжилт энэ хуульд заасан нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавих эрхтэй.

30.6.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний нөхцөлийг Засгийн газрын тухайн зээллэгийн нөхцөлтэй уялдуулан тодорхойлох бөгөөд төсөвт аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтална.

30.7.Энэ хуулийн 32.2-т зааснаас бусад тохиолдолд дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний ерөнхий нөхцөлийг өөрчлөх, гэрээний хугацаа, үндсэн өрийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг сунгах, хүүгийн төлбөрөөс чөлөөлөхийг хориглоно.

31 дүгээр зүйл.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний талуудын үүрэг

31.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, уг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

31.2.Дэд зээлдэгч нь дараах нийтлэг үүрэгтэй:

31.2.1.эцсийн зээлдэгчийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих;

31.2.2.эцсийн зээлдэгч тус бүр дээр зээлийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх;

31.2.3.төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтмол хүргүүлэх, эдгээр тайлан, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангуулах;

31.2.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмнө эцсийн зээлдэгчийн нэгэн адил үүрэг, хариуцлага хүлээх;

31.2.5.тухайн төсөл, арга хэмжээний эрсдэлийг хариуцах;
31.2.6.зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу удирдаж ашиглах.

31.3.Эцсийн зээлдэгч нь дараах нийтлэг үүрэгтэй:

31.3.1.зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу удирдаж ашиглах;

31.3.2.дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх;

31.3.3.дэд зээлдэгчид төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар тайлан, мэдээллийг тогтмол хүргүүлэх, эдгээр тайлан, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдалд хариуцлага хүлээх.

32 дугаар зүйл.Дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрийн үүрэг гүйцэтгүүлэх

32.1.Дэд болон эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэгтэй.

32.2.Тухайн салбарт төрөөс баримталж байгаа бодлого, зохицуулалтаас шалтгаалж дамжуулан зээлдүүлсэн зээл төлөгдөхгүй байх эрсдэл үүссэн тохиолдолд тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ тухай мэдэгдлийг нотлох баримт, тооцоо, судалгааны хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал, дүгнэлт гаргуулахаар нэн даруй хүргүүлнэ.

32.3.Энэ хуулийн 32.2-т заасны дагуу тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт уламжлан Улсын Их Хуралд танилцуулан шийдвэрлүүлнэ.

32.4.Дэд зээлдэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж зээл төлөгдөхгүй байх нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээ болон энэ хуулийн 45.2.3-т заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

32.5.Энэ хуулийн 30.2, 30.3-т заасан гэрээний хүрээнд эцсийн зээлдэгч төлбөрийн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд дэд зээлдэгч нь төлбөрийн үүргийг гүйцэтгэнэ.

32.6.Дэд болон эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд заасан төлбөрийг хугацаа хэтрүүлсэн тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй:



32.6.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төсвийн багцад нь шилжүүлэх санхүүгийн дэмжлэг, ерөнхий орлогын данснаас зээлийн авлагыг суутган тооцох;

32.6.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн хувьд тэдгээрийн арилжааны банкин дахь дансыг хаалгах, холбогдох данснаас авлага барагдуулах хэмжээний хөрөнгийг суутган авах, бусад байгууллагатай харилцан авлагатай бол тухайн байгууллагаас харилцан суутган тооцох;

32.6.3.Монголбанк, арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагаар дамжуулан олгосон зээлийн хувьд гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авах;

32.6.4.хуульд заасны дагуу холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

33 дугаар зүйл.Засгийн газрын өрийн баталгаа, түүнд тавигдах шаардлага

33.1.Засгийн газар нь Хөгжлийн банкны авах зээллэгт болон энэ хуулийн 33.4-т заасан хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болно.

33.2.Засгийн газрын гаргах өрийн баталгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4, энэ хуулийн 17.1-т заасан шаардлагыг хангасан байна.

33.3.Засгийн газрын өрийн баталгаа гаргах зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь энэ хуулийн 18.5.2-18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангасан байна.

33.4.Дараах этгээд нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр зээллэг хийхдээ Засгийн газрын өрийн баталгаа гаргуулахаар тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүсэлт тавьж болно:

33.4.1.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд;

33.4.2.энэ хуулийн 33.4.1-д зааснаас бусад дотоодын хөрөнгө оруулалт бүхий Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд.



33.5.Энэ хуулийн 33.4-т заасан хүсэлтийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

33.6.Энэ хуулийн 33.3-т заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгана.

33.7.Энэ хуулийн 16.1-д заасныг удирдлага болгон Засгийн газрын өрийн баталгаа гаргах асуудлыг энэ хуулийн 33.6-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт тухай бүр танилцуулж шийдвэрлүүлнэ.

33.8.Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын өрийн баталгаа бүхий зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа нь түүнийг санхүүжүүлэх зээллэгийн эргэн төлөх хугацаанаас илүүгүй байна.

33.9.Засгийн газрын өрийн баталгаа нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

33.10.Засгийн газрын өрийн баталгааны хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, тэдгээрийн эрсдэлийн тооцооллыг дараах баримт бичигт тусгана:

33.10.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн танилцуулга;

33.10.2.төсвийн төслийн танилцуулга;

33.10.3.төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

33.11.Энэ хуульд заасан шаардлагыг зөрчиж Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг хориглоно.

34 дүгээр зүйл.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагчид тавигдах шаардлага

34.1.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч /цаашид “баталгаа гаргуулагч” гэх/ гэдэгт Хөгжлийн банк болон энэ хуулийн 33.4-т заасан этгээдийг тус тус ойлгоно.

34.2.Баталгаа гаргуулагч нь дараах шаардлагыг бүрэн хангасан байна:



34.2.1.сүүлийн гурван жил санхүүгийн тайлан тэнцлээр ашигтай ажилласан байх;

34.2.2.хугацаа хэтэрсэн өргүй байх;

34.2.3.зээлдүүлэгч байгууллага нь баталгаа гаргуулагчтай нэгдмэл сонирхолгүй, хамааралгүй этгээд байх;

34.2.4.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь энэ хуулийн 33.3-т заасан шаардлагыг хангасан байх;

34.2.5.холбогдох мэдээлэл, тайлан тооцоо, баримт бичгийг хуульд заасны дагуу, үнэн зөв бүрдүүлсэн байх;

34.2.6.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулж байгаа зээл, үнэт цаасыг эргэн төлөх чадвартай байх.

34.3.Баталгаа гаргуулагч нь дараах нийтлэг үүрэгтэй:

34.3.1.баталгааны гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх;

34.3.2.гэрээнд тусгагдсан нөхцөлөөр зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөх;

34.3.3.төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтмол хүргүүлэх, эдгээр тайлан, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах;

34.3.4.баталгааны сангийн шимтгэлийг тогтоосон хугацаанд бүрэн төлөх;

34.3.5.энэ хуулийн 37.6-д заасны дагуу авлагыг үл маргах журмаар төлж барагдуулах.

34.4.Хөгжлийн банкны хийх зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргаж байгаа тохиолдолд энэ хуулийн 34.2.1-д заасан шаардлага хамаарахгүй.

35 дугаар зүйл.Засгийн газрын өрийн баталгаа гаргах журам

35.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 33.7-д заасныг үндэслэн Засгийн газрын өрийн баталгаа гаргагчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.



35.2.Энэ хуулийн 35.3-т зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 33.4-т заасан этгээдийн хийх зээллэгийн 85 хүртэлх хувьд, Хөгжлийн банкны хийх зээллэгийн 100 хүртэлх хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болно.

35.3.Баталгаа гаргуулагч нь хийх гадаад зээллэгтэйгээ тэнцүү хэмжээгээр өөрийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасыг барьцаалсан тохиолдолд тухайн зээллэгийн нийт дүнд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болох бөгөөд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэлийг баталгаа гаргуулагч этгээд хариуцахаар баталгааны гэрээнд тусгана.

35.4.Хөгжлийн банкны хийх зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийт төсөл, арга хэмжээнд эзлэх нийгмийн үр өгөөжтэй, эргэн төлөх чадваргүй төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 15 хувиас хэтрэхгүй тохиолдолд тухайн зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргана.

35.5.Засгийн газрын гаргах өрийн баталгаа нь тухайн зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөрт хамаарна.

35.6.Засгийн газрын өрийн баталгааны санд баталгаа гаргуулагчийн төлөх шимтгэлийн дүнг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газраас баталж мөрдүүлнэ.

35.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баталгаа гаргуулагч энэ хуулийн 34.2.6-д заасны дагуу зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай эсэхэд эрсдэлийн үнэлгээг хийнэ.

35.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 35.7-д заасан үнэлгээг хийхдээ хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын дэмжлэг, эсхүл зөвлөх үйлчилгээг авч болно.

35.9.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь зээлдүүлэгч болон баталгаа гаргуулагчтай баталгааны гэрээг, баталгаа гаргуулагчтай авлага барагдуулах гэрээг тус тус байгуулна.

35.10.Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам, гэрээний загварыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулж, Засгийн газар баталж, мөрдүүлнэ. Засгийн газрын өрийн баталгааны гэрээнд энэ хуулийн 37.4-т заасан нөхцөлийг тусгана.



35.11.Засгийн газрын өрийн баталгааны гэрээ нь баталгаа гаргуулагч энэ хуулийн 35.6-д заасны дагуу шимтгэл төлснөөр хүчин төгөлдөр болно.

35.12.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн баталгаа бүхий зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ болон гэрээний хэрэгжилт, зээлдэгчийн төлбөрийн чадварын байдалд жил бүр эрсдэлийн үнэлгээ хийнэ.

35.13.Засгийн газрын өрийн баталгаа бүхий зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ болон Засгийн газрын өрийн баталгааны гэрээ, түүний хэрэгжилт энэ хуульд заасан нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавих эрхтэй.

36 дугаар зүйл.Засгийн газрын өрийн баталгааны сан

36.1.Засгийн газрын өрийн баталгааны үүргийн гүйцэтгэлийг хангахад шаардлагатай мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор Засгийн газрын өрийн баталгааны санг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

36.2.Засгийн газрын өрийн баталгааны сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, хяналт, бүртгэл, тайлагналттай холбоотой харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

36.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн баталгааны санд төсвөөс хөрөнгө хуримтлуулах шаардлагатай тохиолдолд хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусган Засгийн газарт хүргүүлнэ.

37 дугаар зүйл.Засгийн газрын өрийн баталгааны сангаас төлбөр гүйцэтгэх

37.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн баталгааны үүрэгтэй холбогдон гарах төлбөрийн үүргийг Засгийн газрын өрийн баталгааны сангаас энэ хуульд заасны дагуу төлж барагдуулна.

37.2.Баталгаа гаргуулагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэж чадахгүй болсон тухай мэдэгдлийг холбогдох нотлох баримт, мэдээлэл болон баталгаа гаргуулагчийн төлбөрийн чадварын талаарх Үндэсний аудитын газраас хийгдсэн шалгалтын дүгнэлтийн хамтаар



санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон зээлдүүлэгчид нэн даруй хүргүүлнэ.

37.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ хуулийн 37.2-т заасан нотолгоо бүхий мэдэгдлийг үнэн зөв болох нь батлагдсан тохиолдолд зээлдүүлэгч талын төлбөрийн нэхэмжлэх дээр үндэслэн Засгийн газрын шийдвэрээр Засгийн газрын өрийн баталгааны сангаас төлбөрийг гүйцэтгэнэ.

37.4. Баталгаа гаргуулагч энэ хуулийн 37.2-т заасан мэдэгдлийг хүргүүлснээс хойш зээлдүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 30 хоногийн дотор баталгааны төлбөрийн нэхэмжлэхийг хүргүүлэх үүрэгтэй.

37.5. Засгийн газрын өрийн баталгааны сангаас төлбөр гүйцэтгэсний дараа тухайн дүнгээр баталгаа гаргуулагч этгээдийн нэр дээр авлага үүсгэнэ.

37.6. Энэ хуулийн 37.5-д заасны дагуу баталгаа гаргуулагчаас авлага барагдуулах ажиллагааг энэ хуулийн 35.9-д заасан гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

37.7. Засгийн газрын өрийн баталгааны үүрэг нь гэрээний үүргээ биелүүлснээр, эсхүл гэрээнд заасан бусад үндэслэлээр дуусгавар болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ӨРИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ БА ХЯНАЛТ

38 дугаар зүйл. Өрийн удирдлагын ил тод байдал, хэрэгжилт

38.1. Хуульд өөрөөр заагаагүй бол улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны талаарх мэдээлэл, бүртгэл, тайлагналт ил тод байна.

38.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өрийн удирдлагын ил тод байдлыг дараах хэлбэрээр хангана:

38.2.1. өр төлбөрийн бүртгэл, тайлагналтыг хууль тогтоомжид зааснаар хэрэгжүүлэх;

38.2.2. улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны талаарх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, бүртгэл хөтлөх, мэдээлэх;



38.2.3.стратегийн баримт бичиг, зээллэгийн төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт, улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон өрийн баталгааны дүн, тооцооллын талаар Улсын Их Хурал, Засгийн газарт тайлагнах.

38.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өр болон өрийн баталгааны үлдэгдлийг улирал бүр, дунд, урт хугацааны өрийн үйлчилгээний төсөөллийг жил бүр тооцоолон гаргаж, олон нийтэд мэдээлнэ.

38.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нийт гадаад өрийг Монголбанкттай хамтран гаргаж, олон нийтэд мэдээлнэ.

38.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нийт гадаад өр, өрийн шалгуур үзүүлэлт, Засгийн газрын өрийн баталгааны талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хагас жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр тайлагнах үүрэгтэй.

39 дүгээр зүйл.Өрийн мэдээллийн нэгдсэн сан

39.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж хөтөлнө.

39.2.Өрийн мэдээллийн нэгдсэн санд дараах мэдээллийг төвлөрүүлнэ:

39.2.1.улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон өрийн баталгааны үлдэгдэл;

39.2.2.Засгийн газар, аймаг, нийслэлийн үнэт цаасны арилжааны мэдээлэл, хуваарь;

39.2.3.Засгийн газрын гадаад зээллэг, тэдгээрийн ашиглалт, гүйцэтгэл, дамжуулан зээлдүүлсэн зээл;

39.2.4.дэд болон эцсийн зээлдэгч, Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагчийн төлбөрийн чадварын байдал, холбогдох гэрээний хэрэгжилт;

39.2.5.Засгийн газрын өрийн баталгаа болон зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаарх мэдээлэл.

39.2.6.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.2-т заасан Засгийн газрын зээл болон баталгаа;



39.2.7.болзошгүй өр төлбөрийн мэдээлэл;

39.2.8.улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын санхүүжилтийн гэрээнээс үүсэх өрийн мэдээлэл;

39.2.9.аймаг, нийслэлийн өрийн мэдээлэл;

39.2.10.Засгийн газрын тусгай сангуудын өрийн мэдээлэл;

39.2.11.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өр;

39.2.12.холбогдох бусад мэдээлэл.

39.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өрийн мэдээллийн нэгдсэн санд энэ хуулийн 39.2-т заасан мэдээллийг тогтмол бүрдүүлж, тухай бүр шинэчилнэ.

39.4.Өрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх зорилгоор энэ хуулийн 39.2-т заасан мэдээллийг дараах байгууллага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тогтмол хүргүүлэх үүрэгтэй:

39.4.1.төсвийн ерөнхийлөн захирагч;

39.4.2.төсвийн төвлөрүүлэн захирагч;

39.4.3.төсвийн санхүүжилт бүхий байгууллага;

39.4.4.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд;

39.4.5.Монголбанк, Хөгжлийн банк;

39.4.6.дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний дэд зээлдэгч болон эцсийн зээлдэгч;

39.4.7.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч;

39.4.8.холбогдох бусад этгээд.

39.5.Өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, төвлөрүүлэх, өр төлбөрийг бүртгэх, тайлагнах журмыг маягт, зааврын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ.

39.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өрийн удирдлагын ил тод байдлыг хангах зорилгоор улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны талаар жилд нэг удаа олон нийтэд мэдээлнэ.



39.7.Энэ хуульд заасан этгээд нь өрийн мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь бүртгэж, хадгалах, хамгаалах үүрэгтэй.

40 дүгээр зүйл.Өрийн бүртгэл

40.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарыг өнөөгийн үнэ цэнээр тооцож, бүртгэнэ.

40.2.Засгийн газрын гадаад зээлийн гэрээний мэдээллийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулах бөгөөд зээлийн ашиглалт гарсан өдрөөс эхлэн өрд бүртгэнэ.

40.3.Засгийн газрын болон аймаг, нийслэлийн үнэт цаасыг төлбөр тооцоо хийгдсэн өдрөөр нь өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, өрд бүртгэнэ.

40.4.Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний мэдээллийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, зээлийн ашиглалт гарснаар авлагад бүртгэнэ.

40.5.Засгийн газрын өрийн баталгааг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулна.

40.6.Энэ хуулийн 37.3-т заасан шийдвэрт үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн өрийн баталгааны Засгийн газрын төлбөл зохих төлбөрийн үүргийн дүнг бүртгэнэ.

40.7.Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, Засгийн газрын өрд бүртгэнэ.

40.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.2-т заасан Засгийн газрын зээл болон Засгийн газрын өрийн баталгааны бүртгэлийг хөтөлнө.

41 дүгээр зүйл.Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бүртгэл

41.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх



төсөл, арга хэмжээг бүртгэх чиг үүргийг гүйцэтгэх бөгөөд энэхүү чиг үүргийн хүрээнд холбогдох этгээдээс шаардлагатай баримт, мэдээллийг гаргуулах эрхтэй.

42 дугаар зүйл. Засгийн газрын өрийн тайлагналт

42.1. Засгийн газрын өрийн мэдээлэл нь нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

42.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

42.2.1. тухайн төсвийн жилийн өрийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаа;

42.2.2. Засгийн газар болон аймаг, нийслэлийн тухайн жилд хийсэн зээллэг, өрийн үйлчилгээний мэдээлэл;

42.2.3. өрийн багцын мэдээлэл, холбогдох зардал, эрсдэлийн шинжилгээ;

42.2.4. Засгийн газрын гаргасан өрийн баталгааны мэдээлэл;

42.2.5. дамжуулан зээлдүүлсэн зээлийн талаарх мэдээлэл;

42.2.6. шаардлагатай бусад мэдээлэл.

42.3. Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төсөл, арга хэмжээний хүрээнд үүсэх, эсхүл үүссэн болзошгүй өр төлбөр, түүнчлэн төсөвтэй холбоотой бусад болзошгүй өр төлбөр, тэдгээрийн эрсдэлийн тооцооллын тухай мэдээллийг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулга хэлбэрээр оруулж тайлагнана.

43 дугаар зүйл. Өрийн удирдлагын хяналт

43.1. Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилтэд Улсын Их Хурал хяналт тавьж, тухай бүр Засгийн газарт чиглэл өгч болно.

43.2. Стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас гурван жил тутам хөндлөнгийн аудит хийх бөгөөд тайланг олон нийтэд ил тод болгоно.

43.3. Өрийн удирдлагын хэрэгжилтэд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу жил бүр дотоод аудит хийнэ.

43.4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл холбогдох эрх бүхий байгууллага нь дотоод



болон хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээг авч, хэрэгжилтийг тайлагнана.

43.5.Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсөл хэрэгжүүлэгч нь тухайн салбарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бөгөөд шаардлагатай бол холбогдох хяналтын байгууллага, албан тушаалтныг оролцуулж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

44 дүгээр зүйл.Хариуцлага хүлээлгэх үндэслэл

44.1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагыг зөрчихөөр бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 18.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн төслийг батлахгүй байх буюу буцаах үндэслэл болно.

44.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 19.6, 19.11-д заасныг зөрчсөн бол Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу Засаг даргыг огцруулах үндэслэл болно.

44.3.Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсөв батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан өрийн хязгаарыг зөрчсөн нь Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндэслэл болно.

44.4.Өрийн удирдлагын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасны дагуу хариуцлага тооцож, албан тушаалаас огцруулсан нь түүнийг эрүүгийн болон захиргааны хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

44.5.Энэ хуульд заасан үнэлгээ хийсэн этгээд нь тухайн үнэлгээний үр дүн, үнэн зөв байдалд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

45 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

45.1.Энэ хуулийн 25.7, 26.12, 29.10, 30.7-д заасныг зөрчсөн холбогдох эрх бүхий этгээд, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн



хөлсний доод хэмжээг тавиас зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, энэ зөрчлийг удаа дараа гаргасан бол төрийн албанд 10 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулна.

45.2.Өрийн удирдлагын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эсхүл санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч дараах шийтгэлийг ногдуулна:

45.2.1.энэ хуулийн 19.8-19.10, 39.4-т заасан тооцоо, санал, төсвийн төсөл, мэдээ, мэдээлэл, тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлээгүй бол буруутай этгээд, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

45.2.2.энэ хуулийн 31.2, 31.3, 34.3, 37.6-д заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

45.2.3.энэ хуулийн 32.4-т заасан буруутай этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, учирсан хохирлыг бүрэн нөхөн төлүүлэх;

45.2.4.энэ хуулийн 39.7-д заасныг зөрчсөн буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

45.2.5.энэ хуульд заасан нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

45.3.Энэ хуулийн 45.2.2, 45.2.3-т заасан шийтгэлийг шүүгч, 45.2.1, 45.2.4, 45.2.5-д заасан шийтгэлийг санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч ногдуулна.

45.4.Зөрчлийн хэлбэр, хүлээлгэх хариуцлагаас үл хамааран энэ хуулийг зөрчсөний улмаас төрд хохирол учруулсан буруутай этгээд уг хохирлыг төлж барагдуулна.



46 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам

46.1.Энэ хуулийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулсан Засгийн газрын зээлийн гэрээ, хэлэлцээр, Засгийн газрын гаргасан үнэт цаас болон өрийн баталгааны нөхцөл нь хүчин төгөлдөр хэвээр байна.

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолын дагуу гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны 2015 оны эхний хагас жилийн байдлаар зарцуулагдаагүй үлдэгдэл хөрөнгийг захиран зарцуулах, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу зохицуулна.

3 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хэлэлцээний шатандаа орсон зээл болон өрийн баталгаа гаргах асуудлыг Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу зохицуулна.

4 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр сарын дотор холбогдох байгууллага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад зээллэг болон өрийн баталгааны талаар тухайн байгууллагад хамаарах аливаа мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй.

5 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хуульд заасан журмыг уг хууль батлагдсанаас хойш зургаан сарын хугацаанд боловсруулж батлах ба шинэ журам батлагдах хүртэлх хугацаанд тухайн харилцааг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмаар зохицуулна.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг:

“6.2.Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаар нь уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газар хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй.

6.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй.”

2/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:

“8.2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасан тусгай шаардлагыг энэ хуулийн 8.1-д зааснаас гадна Засгийн газрын гадаад өрийн багц дахь дийлэнх хувь хэмжээг эзэлж байгаа үндэсний мөнгөн тэмдэгттэй харьцах гадаад валютын Монголбанкнаас зарласан тухайн оны эцсийн албан ханш нь өмнөх оны мөн үеийн албан ханшаас 15 хувь ба түүнээс дээш хувиар өссөн тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно.”

3/10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалт:

“10.1.8.энэ хуулийн 8.2-т заасан үндэслэлээр өрийн тусгай шаардлагыг түр түдгэлзүүлснээс хойшхи хоёр хүртэлх жилийн хугацаанд тусгай шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авах.”

2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Өрийн удирдлагын тухай хууль,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

**1/4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт:**

“4.1.5.“нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого” гэж гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн суурь орлогын нийлбэрээс тухайн төсвийн жилд Хүний хөгжил санд хуримтлагдсан төсвийн орлогыг хассан дүнг;”

2/4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт:

“4.1.8.“Засгийн газрын өр” гэж:

4.1.8.а/өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг;

4.1.8.б/хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг.

3/6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт:

“6.1.4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх.”

4/2 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалт

“12.1.8.Засгийн газрын өрийн нийт хэмжээ;”

4 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “шийдвэрийг гаргаж” гэснийг “шийдвэр болон тусгай шаардлагад нийцүүлэх арга хэмжээг батлах, шаардлагатай гэж үзвэл” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5, 10.1.6 дахь заалтын “8.1-д заасан” гэснийг “8 дугаар зүйлд заасан” гэж, мөн заалтын “түр түдгэлзүүлэх тухай санал” гэснийг “түр түдгэлзүүлэх тухай болон тусгай шаардлагад нийцүүлэх арга хэмжээний санал, шаардлагатай гэж үзвэл” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.9 гэснийг 12.1.10 гэж, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “8.1-д зааснаас” гэснийг “8 дугаар зүйлд зааснаас гэж”, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “улсын нийт” гэснийг “Засгийн газрын” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг:

“3.5.Засгийн газар, орон нутаг өр үүсгэх замаар зээллэг хийх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах, дамжуулан зээлдүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг Өрийн удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.51, 4.1.52 дахь заалт:

“4.1.51.“зээллэг” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.15-д заасныг.

“4.1.52.“гадаадын тусламж” гэж олон улсын байгууллага, түнш орноос Засгийн газрын шугамаар, эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүмүүнлэгийн болон буцалтгүй, техник туслалцааны хэлбэрээр Монгол Улсад олгож байгаа хөрөнгийн эх үүсвэрийг.”

3/10 дугаар зүйлийн 10.1.15 дахь заалт:

“10.1.15.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч үнэлэх, сонгон шалгаруулах журмыг батлах”

4/12 дугаар зүйлийн 12.1.21 дэх заалт:

“12.1.21.гадаадын тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг татвар, хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх санал боловсруулах.”

5/24¹ дүгээр зүйл:

“24¹ дүгээр зүйл.Засгийн газрын зээл олгох

24¹.1.Тухайн жилийн төсвийн хуулиар эх үүсвэр нь батлагдсан тохиолдолд улсын төсвөөс дараах зорилгоор зээл олгож болно:



24¹.1.1.аймаг, нийслэлийн төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх;

24¹.1.2.Засгийн газрын тусгай сангаас хуульд заасан зориулалтаар;

24¹.1.3.Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу дамжуулан зээлдүүлэх.”

6/25 дугаар зүйлийн 25.13, 25.14 дэх хэсэг:

“25.13.Энэ хуулийн 25.11-д заасан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулж, журмын биелэлтийг хангуулна.”

“25.14.Гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага болон буяны байгууллагаас буцалтгүй тусламж болон хүмүүнлэгийн тусламжаар авсан барааг нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх үйл ажиллагаатай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, хэрэгжилтийг хангуулна.”

7/25¹ дүгээр зүйл:

“25¹ дүгээр зүйл.Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр

25¹.1.Хөрөнгө оруулалтын зориулалт бүхий арилжааны нөхцөлтэй Засгийн газрын гадаад зээл болон үнэт цаасны өрийн үйлчилгээний төлбөр, Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийг төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас бууруулах замаар төлнө.

25¹.2.Энэ хуулийн 25¹.1-д заасан төлбөрийг дахин санхүүжүүлэх зориулалтаар үүсгэсэн өрийн үйлчилгээний төлбөрийг төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас бууруулах замаар төлнө.”

8/28 дугаар зүйлийн 28.3.11 дэх заалт:

“28.3.11.Өрийн удирдлагын тухай хууль болон Стратегийн баримт бичигт заасан шаардлага.”

9/30 дугаар зүйлийн 30.5, 30.6 дахь хэсэг:

“30.5.Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.



30.6.Концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд үүсэх болзошгүй өр төлбөр, эрсдэлийн тооцооллын тухай мэдээллийг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулга хэлбэрээр оруулж тайлагнана.”

10/34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт:

“34.1.5.хууль болон гэрээнд зааснаар Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд Засгийн газрын өрийн баталгааны сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон.”

11/52 дугаар зүйлийн 52.5-52.8 дахь хэсэг:

“52.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь болзошгүй өр төлбөрийн бүртгэл, хяналт, зохицуулалт, судалгаа болон магадлал, төсвөөс гарч болох зардлын хэмжээг тооцон бүртгэж, дүгнэлт гаргах, мэдээлэх чиг үүргийг гүйцэтгэнэ.

52.7.Болзошгүй өр төлбөрийн талаар дараах мэдээллийг холбогдох этгээд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй ирүүлэх үүрэгтэй:

52.7.1.Засгийн газрын тусгай сангийн үүсгэсэн өр;

52.7.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өр;

52.7.3.Концессын тухай хуульд заасны дагуу гаргасан баталгаа;

52.7.4.Засгийн газрын өрийн баталгаа гаргасан зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ;

52.7.5.болзошгүй өр төлбөрт хамаарах болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан холбогдох бусад мэдээлэл.

52.8.Болзошгүй өр төлбөрийн хүрээнд улсын төсвөөс тухайн төлбөрийг гүйцэтгэх эрсдэл үүссэн бол тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.”

**12/54 дүгээр зүйлийн 54.5.6 дахь заалт:**

“54.5.6.Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны мэдээлэл.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Өрийн удирдлагын тухай хууль,” гэж, 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалтын “Засгийн газрын” гэсний дараа “өрийн” гэж, “зээл” гэсний өмнө “гадаад” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “Дунд хугацааны” гэсний өмнө “Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг /цаашид “Стратегийн баримт бичиг” гэх/,” гэж, мөн зүйлийн 8.1.1-8.1.4 дэх заалтын “дунд хугацааны” гэсний өмнө “Стратегийн баримт бичиг,” гэж, 8.10.2, 8.10.5 дахь заалтын “төсвийн гүйцэтгэл,” гэсний дараа “Засгийн газрын өрийн тайлан,” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “төсвийн төсөл нь” гэсний дараа “Өрийн удирдлагын тухай хууль болон” гэж, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “28.3.10” гэсний дараа “28.3.11” гэж, 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийн “концессын гэрээ,” гэсний дараа “Засгийн газрын өрийн баталгаа” гэж, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн “төсөвт” гэсний дараа “Өрийн удирдлагын тухай хууль болон” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11, 62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай.

1/25 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

“25.11.Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнахтай холбогдсон харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.”

2/62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсэг:

“62.5.Тусгай зориулалтын шилжүүлгийг өрийн барьцаа болгохыг хориглоно.”

4 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.47 дахь заалтын “улсын өр” гэснийг “Засгийн газрын өр” гэж, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл” гэснийг “Засгийн газрын зээллэг” гэж, 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийн “зээл” гэснийг “гадаад зээллэг” гэж, 33 дугаар зүйлийн 33.2.3 дахь заалтын “өр, гаргах баталгааны дээд хязгаар” гэснийг “өрийн дээд хэмжээ” гэж, 7 дугаар бүлгийн гарчгийн “ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА” гэснийг “БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР” гэж тус тус өөрчилсүгэй.



5 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “28.3.10” гэснийг, 57 дугаар зүйлийн 57.5, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн “50.1.1,” гэснийг, 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсгийн “62.3, 62.4”, 70.4.6 дахь заалтын “49.3,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.44-4.1.46, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.9, 10.1.12 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.6, 11.1.9, 11.1.14 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.10, 12.1.12 дахь заалт, 49-51 дүгээр зүйл, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2-62.4, 62.6, 62.7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийн дугаарыг “30.7” гэж өөрчилсүгэй.

8 дугаар зүйл.Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг:

“3.5.Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас үнэт цаас гаргах, арилжаалахтай холбогдсон харилцааг Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу зохицуулна.”

2/12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсэг:

“12.11.Энэ хуулийн 12.1-12.10 дахь хэсэг нь Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас үнэт цаас гаргах, үнэт цаасны зах зээлд худалдахад хамаарахгүй.”



2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсгийн “Нийтэд” гэснийг “Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргасан үнэт цааснаас бусад нийтэд” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Үнэт цаас” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаас ” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.15.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.22 дахь заалт нэмсүгэй:

“15.1.22.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах.”

2 дугаар зүйл. Төрийн аудитын тухай хуулийн 15.1.22 гэсэн дугаарыг “15.1.23” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Валютын зохицуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “Сангийн яам хөтөлнө” гэснийг “холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөтөлнө” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Валютын зохицуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-14.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмсүгэй:

“5/Өрийн удирдлагын тухай хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа.”

2 дугаар зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 2 дугаар зүйлийн “энэ хууль” гэсний өмнө “Өрийн удирдлагын тухай хууль,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.4.36 дахь заалт:

“5.4.36.Засгийн газрын өрийн баталгааны сан.”

2/6 дугаар зүйлийн 6.4.21 дэх заалт:

“6.4.21.Засгийн газрын өрийн баталгааны сан”

3/9² дугаар зүйл:

“9² дугаар зүйл.Засгийн газрын өрийн баталгааны сан

9².1.Засгийн газрын өрийн баталгааны үүргийн гүйцэтгэлийг хангахад шаардлагатай мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор Засгийн газрын өрийн баталгааны санг байгуулна.

9².2.Засгийн газрын өрийн баталгааны сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

9².2.1.Өрийн удирдлагын тухай хуулийн 35.5-д заасан аргачлалын дагуу тооцсон шимтгэл;

9².2.2.Өрийн удирдлагын тухай хуулийн 37.5-д заасны дагуу авлага барагдуулах замаар хуримтлуулсан хөрөнгө;

9².2.3.Өрийн удирдлагын тухай хуулийн 40.6-д заасан Засгийн газрын өрийн баталгааны төлбөл зохих дүнг төсөвт тодотгол хийн татан төвлөрүүлсэн дүн

9².3.Засгийн газрын өрийн баталгааны сангийн хөрөнгийг Өрийн удирдлагын тухай хуулийн 37.1-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.



9².4.Засгийн газрын өрийн баталгааны хүрээнд үүсэх өр төлбөрийн эрсдэлийг даван туулах нөөц эх үүсвэрийг бүрдүүлэхэд Засгийн газрын өрийн баталгааны сангийн хөрөнгө хүрэлцээгүй болсон тохиолдолд Төсвийн тухай хуулийн 34.1.2, 34.2.2-т заасны дагуу төсөвт тодотгол хийх замаар шийдвэрлэнэ.

9².5.Засгийн газрын өрийн баталгааны санд хөрөнгө хуримтлуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах, төлбөрийн үүрэг гүйцэтгэх тухай журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталж, хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төсвийн тухай,” гэсний дараа “Өрийн удирдлагын тухай” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 3.1.5-д заасныг” гэснийг “Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасныг” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9¹.5 дахь хэсгийн “улсын өрийн” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 16-20 дахь хэсэг нэмсүгэй:

“16.Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана.



17.Орон нутгийн өмчит, орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана.

18.Энэ зүйлийн 16, 17-д заасан зөвшөөрөлд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр богино хугацаанд авах зээл, үнэт цаас хамаарахгүй.

19.Энэ зүйлийн 16, 17-д заасан зөвшөөрөлд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зээл хамаарахгүй.

20.Энэ зүйлийн 16, 17-д заасан зөвшөөрөлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь зээл авах, үнэт цаас гаргахыг хориглоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Концессын тухай хуулийн 30 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 30.6, 30.7 дахь хэсэг нэмсүгэй:

“30.6.Концессын гэрээний дагуу төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эсхүл төлбөр төлөх тохиолдолд Төсвийн тухай хуулийн 30.4-т заасны дагуу уг дэмжлэг, төлбөрийн эх үүсвэрийг төсөвт тусгасан байна.

30.7.Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөл бүхий концессын гэрээ байгуулахад Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг удирдлага болгоно.”



2 дугаар зүйл.Концессын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төсвийн тухай,” гэсний дараа “Өрийн удирдлагын тухай,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай

2 дугаар зүйл.Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ
ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2003 оны 06 дугаар сарын 12-ны өдөр баталсан Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 3.1.5-д” гэснийг “Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай 47² дугаар зүйл нэмсүгэй:

**“47² дугаар зүйл.Стратегийн ач холбогдол бүхий
ашигт малтмалын ордын ашигт малтмалын
нөөц ашигласны тусгай төлбөр**

47².1.Эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг гэрээний нөгөө талд шилжүүлэхээр талууд тохиролцсон тохиолдолд төрийн эзэмшлийн хувь, хэмжээг шилжүүлэн авч байгаа тал буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг энэ хуулийн 47.2-т заасан журмын дагуу тооцож улсын төсөвт төлнө.

47².2.Энэ хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална.

47².3.Энэ хуулийн 5.3-5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байна.”

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 5.3-5.5 дахь хэсэгт “Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН
БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН
БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХЫГ
ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 3, 4 дүгээр зүйл нэмсүгэй:

“3 дугаар зүйл.Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг Засгийн газар батална. Уг журам, гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг 100 хувь урьдчилан байршуулах нөхцөл, хяналт тавих төрийн байгууллагын албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тус тус тусгасан байна.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд өргөдөл ирүүлээгүй болон энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан гэрээ байгуулаагүй бол тухайн ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах бөгөөд дахин тухайн талбайд хайгуулын болон ашиглалтын тусгай



зөвшөөрөл олгохгүй. Энэ зүйлд Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3 дахь заалт болон Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.6 дахь хэсэг хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2 дугаар зүйл.

2.1.2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр баталсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдахаас өмнө ойн сан бүхий газарт олгосон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ойн тухай хуулийн 8.6, 29 дүгээр зүйл, 30.2, 42.1.5-д заасныг хэрэгжүүлнэ. Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг Усны тухай хуулийн 22.3-т заасны дагуу усны сан бүхий газрын эргээс 200 метрээр тогтооно. Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхацсан тохиолдолд Усны тухай, Ойн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

2.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн аймгийн Засаг дарга гэрээ байгуулж, хяналтыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

2.3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд нөхөн сэргээлт хийхэд гаргах зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрийн ашиглалт явуулсан хугацаанд олсон орлоготой нь уялдуулан нөхөж гаргуулна.”

3 дугаар зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “тусгай зөвшөөрлийг энэ хууль батлагдсанаас хойш 5 сарын хугацаанд цуцална” гэснийг “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг хүсвэл 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр баталсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван



сарын дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өргөдөл гаргана” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд дараах агуулгатай
56.1.8 дугаар заалт нэмсүгэй:

“56.1.8.Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалт болон хуулийн дагуу байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

**““Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулахтай
холбогдуулан авах арга хэмжээний тухай”
тогтоол хүчингүй болсонд тооцох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан ““Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 58 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

“Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 74 дүгээр тогтоолын “худалдааны” гэснийг хассугай.

2. Энэ тогтоолыг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолын “эдийн засгийн” гэснийг, мөн тогтоолын 1 дэх заалтын “худалдаа, үйлдвэрлэл, аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах” гэснийг тус тус хассугай.

2. Энэ тогтоолыг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

““Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 38 дугаар тогтоолын “худалдааны” гэснийг хассугай.

2.“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 38 дугаар тогтоолын 2-4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

3.Энэ тогтоолыг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газар чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, орлого бүрдүүлэлт, төсвийн хариуцлага, ил тод байдлыг сайжруулах, экспортын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/жил бүрийн Монгол Улсын төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа эдийн засгийн тогтвортой өсөлт болон валютын ханшны тогтвортой байдлыг богино, дунд, урт хугацаанд бий болгох үндсэн зорилтын хүрээнд гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалт, экспортын орлогыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих арга хэмжээг тусгах;



2/Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр худалдах, худалдан авах замаар хөрөнгийн зах зээлд оролцох, санхүүжилт босгох зорилтыг хэрэгжүүлэх, олон улсын хөрөнгийн зах зээлд Монгол Улсын нэр хүндийг өсгөх боломжийг судалж хэрэгжүүлэх;

3/Гол нэр төрлийн эрдэс баялгийн үйлдвэрлэлийн биет хэмжээг тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл болон уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн санал, тухайн салбарын урт, дунд хугацааны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний төсөөлөлд үндэслэн тооцоолдог аргачлалыг боловсруулж мөрдүүлэх, орлогын бүрдүүлэлтийг сайжруулах чиглэлээр нөөц бололцоогоо бүрэн дайчлах;

4/улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутаг барьсан болон барьж байгаа худалдааны төвүүдийн барилгын ажлыг дуусгаж, хувийн хэвшилд худалдаж, орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлэх;

5/Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн менежментийг боловсронгуй болгож, уг сангийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах;

6/аймгийн төвийн сумдыг татан буулгаж, аймгийн төвийг хот болгох асуудлыг 2017 оноос эхлэн хэрэгжиж эхлэхээр хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7/эдийн засгийн ил тод байдлыг хангах хүрээнд худалдаа, үйлчилгээний байгууллагын борлуулалтын орлогыг кассын машины баримтад үндэслэн тооцож татвар, хураамжийг ногдуулдаг тогтолцоог судалгаанд үндэслэн боловсронгуй болгох арга хэмжээг авах;

8/боловсрол, эрүүл мэндийн салбарын засаглалыг сайжруулж улс төрөөс хараат бус, бие даасан байдлыг бүрдүүлэх, эдгээр салбарын ажилчдын цалин, урамшууллыг мэргэжлийн зэрэг, ур чадварыг харгалзан тооцох тогтолцоог бүрдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих болон хариуцлагыг сайжруулах чиглэлээр судалгаа хийж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

9/эдийн засаг дахь төрийн оролцоог зохистой түвшинд хязгаарлах, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх төсөл, арга хэмжээ, төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэх төсөл, арга хэмжээг ангилж санхүүжүүлэх талаар судалж, саналаа танилцуулах;



10/цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж, экспортлох асуудлаар нэгдсэн бодлого боловсруулж 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;

11/энэ тогтоолын 1 дэх заалтын 10 дахь дэд заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Б.Болор/-нд, энэ тогтоолын хэрэгжилтийн талаар жил бүр Төсвийн байнгын хороонд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2015 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын
ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай;

2/”Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/ Монгол Улсын 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;

4/”Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны санхүүгийн нэгдсэн тайлан;



5/"Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

6/Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
7/"Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

8/Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9/"Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

10/Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төсөл;

11/"Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

12/Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл;

13/Худалдааны тухай хуулийн төсөл

14/Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

15/Нягтлан бодох, бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

16/Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төсөл;

17/Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төсөл;

18/Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл;

19/Хөрөнгийн албан татварын тухай болон холбогдох бусад хуулийн төсөл;

20/"Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

21/Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай болон холбогдох бусад хуулийн төсөл;



22/Нийтийн сонсголын тухай болон холбогдох бусад хуулийн төсөл;

23/Хяналтын тухай болон холбогдох бусад хуулийн төсөл;
24/Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

25/Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

26/Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
27/Зөрчлийн тухай хуулийн төсөл;
28/Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

29/Монгол Улсын сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл;
30/Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслүүд;

31/Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл;

32/Казиногийн тухай хуулийн төсөл;
33/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

34/бусад.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/- тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Цэдэн-Ишийн Болдсайхан, Чойнзонгийн Содномцэрэн, Рэнцэнгийн Содхүү нарыг томилсугай.

2.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс Батнямын Алтанжаргалыг чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоолын 2 дахь заалтын 1 дэх дэд заалтын “... хонины ноос, тэмээний ноосны килограмм тутамд 2000” гэснийг “ноосыг малын ашиг шим, үүлдэрлэг байдал, ноосны чанараас хамааруулан 2014 оноос эхлэн хонины ноос, тэмээний ноосны килограмм тутамд 1000-2000” гэж өөрчилсүгэй.



2.Энэ тогтоолыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

**Эдийн засгийн хүндрэлээс гарах арга
хэмжээний хөтөлбөр батлах тухай**

Эдийн засгийн хүндрэлийг даван туулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг хамтран боловсруулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/-нд үүрэг болгосугай.

3.“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож, хөтөлбөрт заасан хугацаанд хэрэгжээгүй заалт бүрийг хариуцах албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэж, хөтөлбөрийн биелэлтийг хагас жил тутамд Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Батсуурь/-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2015 оны
41 дүгээр тогтоолын хавсралт

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛЭЭС ГАРАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Нэгдүгээр чиглэл. Макро эдийн засгийг тогтворжуулах
Ботино хугацаанд үр дүн гарах арга хэмжээ

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах этгээд	Хүрэх үр дүн	
					Харьцуулах суурь үзүүлэлт	2016 оны эцэст
1.	Төсвийн нэгдмэл, ил тод, хариуцлагатай бодлого хэрэгжүүлж, бизнесийг дэмжих					
	Төсвийн нэгдмэл байдлыг хангаж, ил тод байдлыг дээшлүүлэн, алдагдлын хэмжээг зохистой түвшинд хүргэх	Нэгдсэн төсвийн 2016-2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд төсвөөс гадуурх зардлыг багтаасан нэгдсэн төсвийн алдагдал болон улсын өрийн ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар бууруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах	2016 он	Сангийн яам, Хөгжлийн банк	Төсвөөс гадуурх зардлыг багтаасан нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь-5.0	Төсвөөс гадуурх зардлыг багтаасан нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь-4.0
1.1.		Хөгжлийн банкны бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлан, төслүүдэд олгосон санхүүжилт, санхүүжилтийн нөхцөл, эргэн төлөлт зэрэг мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу нийтэд мэдээлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам, Хөгжлийн банк	Тайлан нийтлэгдээгүй	Хөгжлийн банкны бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлан, төслийн санхүүжилтийн талаар мэдээлнэ.
1.2.	Засгийн газрын өрийн	Өрийн удирдлагын тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулж, өрийн менежментийг сайжруулах	2015 оны эхний хагас жил	Сангийн яам, Монголбанк	Улсын өрийн 2015 оны ДНБ-д эзлэх хувь-58.3	Улсын өрийн 2016 оны ДНБ-д эзлэх хувь-55.0
1.3.	Удирдлагыг сайжруулах	Засгийн газар Монголбанктэй хамтран улсын гадаад өрийн үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам, Монголбанк		Төлөвлөгөө хэрэгжиж эхэлнэ.
1.4.	Татварын бодлогоор эдийн засгийг дэмжих	Бага орлоготой иргэд, жижиг, дунд үйлдвэрийн татварын хувь хэмжээг бууруулах замаар дэмжлэг үзүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжиж, ажлын байр нэмэгдэнэ.



1.5.		Татварыг ангийн ойлгомжтой болгон олон улсын жишигт нийцсэн шинэчлэл хийх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Хуулиуд хэрэгжиж эхэлсэн байна.
2.	Санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, мөнгөний бодлогоор эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих					
	Улсын Их Хурлын 2014 оны 69 дүгээр тогтоолоор баталсан мөнгөний бодлогын үндсэн зорилт, чиглэлийг хэрэгжүүлж ажлалгах					Хөтөлбөрийн үлдсэн хэсгийг Засгийн газарт шилжүүлж авсан байна.
2.1.		Хөтөлбөрийн зөвлөс Монголбанкны тэнцэлд үлдэх хэсгийг Засгийн газарт шилжүүлэх	2015 оны эхний хагас жил	Монголбанк, Сангийн яам		
2.2.	Банкны салбарт эрсдэл хуримтлагдах, зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авах		2015 оны эхний хагас жил	Монголбанк		Санхүүгийн тогтвортой байдал хадгалагдана.
2.3.	Санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах	Банкны салбарт системийн шинжтэй эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулах хүрээнд Монголбанк болон төрийн бусад холбогдох байгууллагад шаардлагатай мэдээлэл солилцоо тогтоцоо, хяналт, зохицуулалтын арга хэрэгслийг сайжруулах	2015 оны эхний хагас жил	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл		Эрсдөлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо сайжирсан байна.
3.	Нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх					
3.1.		Хөдөлмөр эрхлэлтийн сангийн хэмжээг тогтвортой хадгалж, ажил эрхлэлтийг дэмжих	2015 он	Хөдөлмөрийн яам		
3.2.		Ажлын байр хадгалах болон их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төсөгчдийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2015 он	Хөдөлмөрийн яам		
3.3.	Ажил эрхлэлтийг дэмжих	Эрсдэлийн түвшин өндөртэй ажлын байранд ажиллагсдыг ажил олгогч амь нас, эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	2015 он	Хөдөлмөрийн яам		Ажилгүйдлийн түвшин 6.9 хувь болсон байна.



3.4.		Инфляци, бүтээмжтэй уялдуулан цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бий болгох	2015 он	Хөдөлмөрийн яам		
3.5.	Эдийн засгийн хүндрэлийн нийгмийн эмзэг хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Зорилгот бүлэгт чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх	2015-2016 он	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам		Ядуурлын түвшин 26.0 хувь болсон байна.
3.6.		Ажилгүйдлийн тэтгэмж авах хугацааг сунгах болон ажилгүй болсон иргэдийг богино хугацаанд дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2015 он	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яам		
4.	Монгол Улсад итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх					
4.1.		Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгаж, бизнест ээлтэй орчныг бүрдүүлэх	2015-2016 он	Засгийн газрын бүх түвшинд		Бизнесийн орчин сайжирч, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
4.2.		Хөрөнгө оруулагчдад чанартай, шуурхай, найрсаг, ойлгомжтой, хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор нэг цэлийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх	2015 оны 2 дугаар хагас жил	Хөрөнгө оруулалтын газар		Нэг цэлийн үйлчилгээ нэвтэрсэн байна.
4.3.	Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах	Хөрөнгө оруулагчдад учирдаг дарамт, шахалт, хүнд суртлыг багасгах зорилгоор Хөрөнгө оруулалтын газарт Хөрөнгө оруулагчтай холбоотой аливаа асуудлаар үйлчилгээ үзүүлэх, хамгаалах эрхийг олгох	2015 оны 2 дугаар хагас жил	Хөрөнгө оруулалтын газар		Эрх олгогдсон байна.
4.4.		Монгол Улсын бизнесийн орчны талаар зөв ойлголт өгч, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаад орнуудын Засгийн газар, хөрөнгө оруулалт хариуцсан байгууллагатай хамтарч ажиллах	2015-2016 он	Хөрөнгө оруулалтын газар		2-оос доошгүй оронтой хөрөнгө оруулалт харилцан дэмжих гэрээ байгуулсан байна.
4.5.		Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, боломжийн талаар гадаад сурталчилгааг өргөжүүлж, санхүүжүүлэхэд бэлэн төслүүдийг хөрөнгө оруулагчдад танилцуулах	2015-2016 он	Хөрөнгө оруулалтын газар		Хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.

Дунд хугацаанд үр дүн гарах арга хэмжээ

Төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого авч хэрэгжүүлэх						
5.			Эдийн засгийн хүндрэл, онцгой нөхцөл байдал үүсэхэд санхүүгийн дутагдалд орохгүй байх хэмжээнд төсвийн тогтворжуулалтын санг бүрдүүлэх, сангийн санхүүгийн менежментийг бие даасан, хараат бус нэгжээр хийлгэж, илүү үр ашигтай болгох чиглэлээр хууль эрх зүйн орчныг өөрчлөх	2015 оны эцэс жил	Сангийн яам	Тогтворжуулалтын сангийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэнэ.
5.1.	Засгийн газрын хуримтлалын тогтолцоог сайжруулах					
5.2.		Ирээдүйн өв сангийн тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулж, Үндэсний баялгийн сан байгуулах		2015 оны 2 дугаар хагас жил	Сангийн яам	Баялгийн сан байгуулагдсан байна.

Хоёрдугаар чиглэл-Эдийн засгийн өсөлтийг дэмжих
Болино хугацаанд үр дүн гарах арга хэмжээ

Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх						
6.			Оюутолгойн төслийн хөрөнгө оруулагч талтай хэтэлцээр хийж, далд уурхайн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	2015 оны 2 дугаар хагас жил	Монгол Улсын сайд	1.2 тэрбум ам.доллар
6.1.	Зогсонги байдалд орсон томоохон					
6.2.	Төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Тавдугаар цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэгчтэй Засгийн газар цахилгаан болон дулааны эрчим хүч худалдан авах гэрээ, газар ашиглах гэрээг байгуулж, төслийг эхлүүлэх		2015 оны эхний хагас жил	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам	240.0 сая ам.доллар
6.3.	Хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Тавантолгойн цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлэх		2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам	Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна.
6.4.		Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх		2015 оны 2 дугаар хагас жил	Зам, тээврийн яам	Барилгын ажил эхэлсэн байна.



7. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлуулах						
	Алтны олборлолтыг нэмэгдүүлэх	Алт олборлох аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, алтыг худалдан авах нөхцөлтэйгээр урьдчилгаа олгох, урьдчилан худалдан авах зэргээр олборлолтыг нэмэгдүүлэх	2015 оны эхний хагас жил	Монголбанк, Уул уурхайн яам		20 тонн алт олборлоно.
7.1.		Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, алтны тодорхой ордуудыг ашиглах	2015 оны эхний хагас жил	Уул уурхайн яам		10 тонн алт олборлоно.
7.3.	Төмрийн хүдрийн баяжмалын экспортыг нэмэгдүүлэх	Төмрийн хүдрийн баяжмалын борлуулалтыг нэмэгдүүлэх	2015 оны 2 дугаар хагас жил	Уул уурхайн яам, Гадаад хэргийн яам		2016 оноос жил бүр 10 сая тн-оос доошгүй экспортолно.
7.4.	Импортыг орлох үйлдвэрийг дэмжих	Цементийн үйлдвэрийн төслүүдэд Хөгжлийн банкнаас санхүүжилт олгох	2015 оны эхний хагас жил	Хөгжлийн банк		2 сая тонн цементийн хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээс нэмж хангана.
7.5.		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг өөрчилж, төрөөс дотоодын бараа, бүтээгдэхүүнийг түлхүү худалдан авах замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		
7.6.	Экспортыг нэмэгдүүлэх	Гадаад орнуудтай байгуулсан хөнгөлөлтийн ерөнхий тогтолцоог /GSP/ өргөжүүлэх замаар экспортын үйлдвэрлэлийн эрэлтийг нэмэгдүүлэх	2015 оны эхний хагас жил	Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам		Экспортын үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлт нэмэгдсэн байна.

8.	Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх						
8.1.	Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар эдийн засгийг дэмжих	Олон улсын зах зээлд Төрийн банкны бонд гаргах	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		300.0 сая ам.долларын бонд босгосон байна.	

Дунд хугацаанд үр дүн гарах арга хэмжээ

9.	Дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх						
9.1.	Концессын гэрээ байгуулсан төслүүдийг эрчимжүүлэх	Туул-Сонгины усны нөөцийн цогцолбор байгуулж, усан цэнэгт цахилгаан станц байгуулах төслийг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн ажил эхэлсэн байна.	
9.2.		Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто замын төслийг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2016 он	Зам, тээврийн яам, Аж үйлдвэрийн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	
9.3.		Багануурын 700 МВт-ын цахилгаан станцын төслийн барилгын ажлыг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	
9.4.	Концессын гэрээ байгуулах шатанд байгаа төслүүдийг эрчимжүүлэх	Чандганы 600 МВт-ын цахилгаан станцын төслийн барилгын ажлыг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна.	
9.5.		Улаанбаатар-Мандалговь, Багануур-Өндөрхаан-Чойбалсан, Багануур-Чойр, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барих ажлыг эхлүүлэх /Барих-шилжүүлэх/	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн ажил эхэлсэн байна.	
9.6.		Дорнодын 100 МВт-ын цахилгаан станц төслийн барилгын ажлыг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2015 оны эхний хагас жил	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн ажил эхэлсэн байна.	



9.7.		Хөшгийн хөндийн нисэх буудал болон нийслэлийг холбох хурдны авто замын төслийг эхлүүлэх /Барих-шилжүүлэх/	2015 он	Зам, тээврийн яам, Аж үйлдвэрийн яам	Барилгын ажил эхэлсэн байна.
9.8.		Аймгийн төвийг нийслэл хоттой болон бусад аймгуудтай холбох авто замын төслүүдийг хэрэгжүүлэх /Барих-шилжүүлэх/	2016 он	Зам, тээврийн яам, Аж үйлдвэрийн яам	Барилгын ажил эхэлсэн байна.
9.9.		Концессын бусад төслүүдийн бэлтгэл ажлыг хангаж, эхлүүлэх	2016 он	Аж үйлдвэрийн яам	Бэлтгэл ажил хангагдсан байна.
9.10.	Экспортын болон транзит тээврийг нэмэгдүүлэх	Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ажлыг эхлүүлэх /Барих-ашиглах-шилжүүлэх/	2016 он	Зам, тээврийн яам	Барилгын ажил эхэлсэн байна.
9.11.		Төмөр замын босоо тэнхлэгийн замыг хос болгох, Улаанбаатар хотын дундуур тавих төмөр замыг Богд уулын урдуур тойруулан барих ажлыг эхлүүлэх	2016 он	Зам, тээврийн яам	Бэлтгэл ажил хангагдсан байна.
10.		Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлуулах			
10.1.	Алтны олборлолтыг нэмэгдүүлэх	Улсын хилийн зурвас газар дахь алтны зарим ордуудыг тусгай хамгаалалттай газрын ангиллаас гаргах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	2015 он	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Уул уурхайн яам	Улсын Их Хурлаас холбогдох шийдвэр гарсан байна.
10.2.		Эрдэнэтийн-Овоо ордын төвийн хэсгийг ашиглах замаар тус ордын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	2016 он	Уул уурхайн яам	Барилгын ажил эхэлсэн байна.
10.3.	Зэсийн баяжмал, цэвэр зэсийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөх	Цагаан суваргын ордын төслийн санхүүжилтийг шийдвэрлэж, төслийг эхлүүлэх	2016 он	Уул уурхайн яам, Сангийн яам	Төслийн бэлтгэл ажил дууссан байна.
10.4.		Зэс хайлуулах үйлдвэр байгуулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх	2016 он	Аж үйлдвэрийн яам, Уул уурхайн яам	Төслийн санхүүжилт шийдвэрлэгдсэн байна.



10.5.		Тарифын болон тарифын бус саад тогторыг бууруулж, ОХУ, БНХАУ болон бусад томоохон зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортолж боломжийг бүрдүүлэх	2016 он	Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам		Тариф буурсан байна. Зарим бараанд ногдуулсан квотыг нэмэгдүүлсэн байна.
10.6.	Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх	Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулж, худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах	2015 эхний хагас жил	Гадаад хэргийн яам		Япон улсад экспортолж хэмжээ нэмэгдсэн байна.
10.7.		Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрийн төслүүдийг Хөгжлийн Банкнаас санхүүжүүлэх, эх үүсвэрийг нэмэгдүүлэх	2015-2016 он	Аж үйлдвэрийн яам, Хөгжлийн банк		300.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
10.8.		Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэгчдэд Хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл олгох	2015-2016 он	Аж үйлдвэрийн яам, Хөгжлийн банк		80.0 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.
10.9.		Ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төслүүдэд Хөгжлийн Банкнаас хөнгөлөлттэй зээл олгох	2015-2016 он	Аж үйлдвэрийн яам, Хөгжлийн банк		100.0 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.
10.10.		Чөлөөт бус болон казино байгуулах, гадаад сурталчилгааг нэмэгдүүлэх, визийг хөнгөвчлөх, жуулчдын аюулгүй ая тухтай аялах боломжийг бүрдүүлэх зэргээр аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх	2015-2016 он	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам	2014 онд 190.0 сая ам.доллар	Аялал жуулчлалын орлого 250.0 сая ам.долларт хүрсэн байна.
10.11.		Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах үүднээс Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг барих санхүүжилтийг шийдвэрлэх	2015-2016 он	Сангийн яам, Зам, тээврийн яам		



10.12.		Дэлхийн худалдааны байгууллагатай тохирсон хэмжээний дотор импортын зарим бараанд ногдуулах гаалийн татварыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	2016 он	Сангийн яам, Аж үйлдвэрийн яам	5.0 хувь	Зарим барааны татвар 10-20 хувь болсон байна. Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна. Барилгын ажил эхэлсэн байна.	
10.13.	Импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих	Нүүрснээс шингэн болон хийн түлш гарган авах үйлдвэрүүдийг зарим нүүрсний ордуудад түшиглэн байгуулах төслийн бэлтгэл ажлыг хангах	2016 он	Аж үйлдвэрийн яам		Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна.	
10.14.		Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	2016 он	Аж үйлдвэрийн яам		Барилгын ажил эхэлсэн байна.	
10.15.		Эгийн голын усан цахилгаан станцын төслийн бэлтгэл ажлыг хангаж, эхлүүлэх	2016 он	Эрчим хүчний яам, Аж үйлдвэрийн яам		Төслийн бэлтгэл ажил хангагдсан байна.	
11.	Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх						
11.1.	Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар эдийн засгийг дэмжих	Засгийн газрын баталгааны болон зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг өргөжүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Хууль батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна.	
11.2.		Хөрөнгө оруулалтын санг гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Сангийн үйл ажиллагаа жигдэрсэн байна.	
11.3.		Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах	2015 оны эхний хагас жил	Сангийн яам		Давхар даатгалын корпораци байгуулагдсан байна.	
11.4.		Үйлдвэржилтийг дэмжсэн санхүүгийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бизнес эрхлэгчдэд учирдаг эрсдлийг багасгах, санхүүжилтийн өртгийг бууруулах зорилгоор хувийн хэвшилтэй хамтран экспортын даатгалын компани, тоног төхөөрөмжийн лизингийн компани байгуулах	2015 оны эхний хагас жил	Сангийн яам, Хөгжлийн банк		Экспортын даатгалын компани, тоног төхөөрөмжийн лизингийн компаниуд байгуулагдсан байна.	

11.5.		Барилга угсралтын ажлын даатгал, эмчийн харилцааны даатгал, хуульчийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2015 оны эхний хагас жил	Сангийн яам	Хууль батлагдаж, хэрэгжиж эхэлсэн байна.
12.	Эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх, бизнесийн орчинг сайжруулах				
12.1.		Түлш, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар чөлөөлж, тус салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эрчим хүчний шинэ эх үүсвэр болон дамжуулах шугамыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд шилжүүлэх	2015 оны эхний хагас жил	Эрчим хүчний яам	Улсын Их Хурал, Засгийн газраас холбогдох шийдвэр гарсан байна.
12.2.	Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, оновчтой болгох	Төрийн өмчийн хороо болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын тогтолцоог корпорацийн засаглалд шилжүүлж, бие даасан байдал, үр ашгийг дээшлүүлэх, Засгийн газраас төрийн өмчит компанитай зөвхөн татвар ногдуулах, ногдол ашиг хуваарилах байдлаар харилцдаг болох чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2015 оны эхний хагас жил	Төрийн өмчийн хороо	Улсын Их Хурал, Засгийн газраас холбогдох шийдвэр гарсан байна.
12.3.		Төрийн өмчийг хувьчлах өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлуулж, төрийн өмчит компаниудыг Хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах тогтолцоог бий болгох	2015 оны эхний хагас жил	Сангийн яам, Төрийн өмчийн хороо	Улсын Их Хурал, Засгийн газраас шийдвэр гарсан байна.
12.4.	Газрын харилцааг боловсронгуй болгох	Газрыг эдийн засгийн харилцаанд бүрэн оруулж, урт хугацаанд тогтвортой хөрөнгө оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Газрын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2015 оны 2 дугаар хагас жил	Барилга, хот байгуулалтын яам	Хууль батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Өрийн удирдлагын тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өрийн удирдлагын тухай хууль баталсантай холбогдуулан Гадаадын тусламжийн харилцааг зохицуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг 2015 оны 4 дүгээр улиралд багтаан боловсруулж, хэрэгжилтийг хангуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

2.Өрийн удирдлагын тухай хууль баталсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гадаадын зээл, тусламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 19 дүгээр тогтоолыг Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Чойнзонгийн Содномцэрэнг улируулан томилсугай.

2.Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргаар Цэдэн-Ишийн Болдсайханг томилсугай.



3.Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Батнямын Алтанжаргалыг чөлөөлсүгэй.

4.Энэ тогтоолыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

**Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Самбуугийн Дэмбэрэлийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Жалбасүрэнгийн Батзанданг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Самбуугийн Дэмбэрэлийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Догсомын Батцогтыг Төсвийн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Н.Адъяабат, Б.Суманчулуун нарт олгосон улсын цолыг хасах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны “Сэргээшийн шинжилгээний дүгнэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Их Монгол улс байгуулагдсаны 808 жилийн ой, Ардын хувьсгалын 93 жилийн ойн баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд шөвгөрсөн бөхчүүдээс сэргээшийн шинжилгээ авснаас сэргээш хэрэглэсэн нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон Архангай аймгийн Тариат сумын харьяат Найдангийн Адъяабат, Говь-Алтай аймгийн Тонхил сумын харьяат Балжиннямын Суманчулуун нарт олгосон Улсын начин цолыг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: tugui_medeelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 8

Индекс: 14003